

## ТӨВ АЙМГИЙН ХЭМЖЭЭНД 2022 ОНЫ 01 ДҮГЭЭР САРД ХИЙСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН, МЭДЭЭ

2022 оны 01 дүгээр сарын 31

Зуунмод

Төв аймгийн нутгийн өөрөө удирдах байгууллага, нутгийн захиргааны байгууллагын хэмжээнд 2022 оны 01 дүгээр сард хийсэн ажлын мэдээллийг танилцуулж байна.

### **Нэг. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын алба:**

Аймгийн ИТХ-ын Ажлын албанаас 2022 оны 01 дүгээр сард дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Монгол Улсад Шинэ Үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ой, Монгол Улсын Үндсэн хуулийн өдрийг тохиолдуулан тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 11 хэрэгжүүлэх арга хэмжээтэйгээр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргаар батлуулан хэрэгжилтийг ханган ажиллалаа.

Тус ажлын хүрээнд Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг сурталчлах, таниулах, хуулийг биелүүлэх, хүндэтгэх, хууль дээдлэх ёсыг залуу хойч үед төлөвшүүлэх, сурталчлан таниулах зорилгоор “Цахим илтгэлийн уралдаан”, “Үндсэн хууль” сэдэвт чөлленж, төрийн албан хаагчдын дунд спортын 3 төрөлт тэмцээн зохион байгуулав. Тус тэмцээн уралдаанд шалгарсан оролцогчдын шагналыг аймгийн ИТХ-ын дарга Ц.Жамбалсүрэн, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Жавзанпагма нар гардууллаа.

Мөн Төв аймгаас сонгогдсон Ардын Их Хурлын депутатуудад хүндэтгэл үзүүлэх арга хэмжээг Улаанбаатар хотод зохион байгуулж, нийт 14 депутат оролцлоо. Эдгээр депутатуудаас дурсамж яриа авч, видео мэдээлэл бэлтгэн нийтэд мэдээллээ.

Жендерийн Үндэсний хорооноос аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хүйсийн тэнцвэрт байдлын тайлан, Жендерийн эрх тэгш байдлыг хангах төрийн бодлогын хэрэгжилтийн тайланг ирүүлэх 2021 оны 03/217 тоот албан бичгийн дагуу аймаг, сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч нарын хүйсийн тэнцвэрт байдлын мэдээ болон багийн иргэдийн нийтийн хурлын мэдээллийг цахим программд оруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн даргын 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 11 дүгээр албан бичгээр тайланг нэгтгэн хүргүүлэв.

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны тайлан мэдээ, хавсралт судалгаа, нутгийн өөрөө удирдах байгууллагын мэдээг нэгтгэн, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлээд байна.

Сонгуулийн Ерөнхий хорооны 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн 1/06 тоот албан бичгийн дагуу Бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа төлөөлөгчийн тоо, Тухайн орон нутгаас шилжсэн төлөөлөгчийн тоо, Төрийн жинхэнэ албанд томилогдсон төлөөлөгчийн тоо, өөр орон нутагт амьдардаг төлөөлөгчийн тоо, 2020 оны ээлжит сонгуулиас хойш ИТХ хуралдсан тоо зэрэг судалгаа, мэдээллийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, 27 сумдын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчдөөр тоон болон дэлгэрэнгүйгээр нэгтгэн гаргаж, СЕХ-нд хүргүүллээ.

Дээрх судалгаануудын дүнгээс товч танилцуулбал:-

Төв аймгийн ИТХ-д бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа төлөөлөгчийн тоо 41, тухайн орон нутгаас шилжсэн төлөөлөгч, төрийн жинхэнэ албанд томилогдсон төлөөлөгч байхгүй бөгөөд өөр орон нутагт амьдардаг төлөөлөгч 9, 2020 оны ээлжит сонгуулиас хойш нийт 9 удаа хуралдсан байна.

Төв аймгийн 27 сумдын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа төлөөлөгчийн нийт тоо 533, тухайн орон нутгаас шилжсэн төлөөлөгч 1, төрийн жинхэнэ албанд томилогдсон төлөөлөгч 5, өөр орон нутагт амьдардаг төлөөлөгч 26, 2020 оны ээлжит сонгуулиас хойш сумдын ИТХ-ууд 162 удаа хуралджээ.

Төв аймгийн хэмжээнд нийт төлөөлөгчийн тоо 582, үүнээс бүрэн эрхээ хэрэгжүүлж байгаа төлөөлөгчийн тоо 576 (нас барсан төлөөлөгч 2), тухайн орон нутгаас шилжсэн төлөөлөгчийн тоо 1, төрийн жинхэнэ албанд томилогдсон төлөөлөгчийн тоо 5, өөр орон нутагт амьдардаг төлөөлөгч 35, 2020 оны ээлжит сонгуулиас хуралдсан ИТХ-ын тоо 171 байна.

2022 оны 01 дүгээр сард Төрийн төв болон орон нутгийн байгууллагуудаас 29 албан бичиг хүлээн авч 31 албан бичиг гаргав. Үүнээс хариу өгч шийдвэрлэх 5 бичиг бүртгэгдэж хариуг өгч шийдвэрлэсэн байна.

Энэ сард аймгийн ИТХ-д иргэн Б.Эрдэнэтуяагаас ирсэн байрны асуудал шийдвэрлүүлэх тухай 1 өргөдлийг хяналтын карт нээж шийдвэрлэх шатандаа байна.

Төв аймгийн нутгийн удирдлагын байгууллагуудаас худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний салбарын үе үеийн ажиллагсдад зориулан “Монгол Улсад Үндэсний худалдаа үүсэж хөгжсөний 100 жил” ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгууллаа.

Уг арга хэмжээнд Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал, Ц.Туваан, Төв аймгийн ИТХ-ын дарга, аймгийн Худалдаа, аж үйлдвэрийн танхимын дарга Ц.Жамбалсүрэн, Төв аймгийн Засаг дарга Д.Мөнхбаатар, аймгийн Засаг даргын орлогч, Худалдааны салбар үүсэж хөгжсөний 100 жилийн ойг тэмдэглэх ажлын хэсгийн дарга Г.Сурмаа, ЗГХЭГ-ын ХШҮДАГ-ын дарга Э.Бат-Идэр, ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалцэрэн болон худалдаа, нийтийн хоол, үйлчилгээний салбараас төрөн гарсан алдартан гавьяатнууд, үе үеийн ажилтан, албан хаагчид оролцлоо.

Худалдаа, нийтийн хоолны салбараас Худалдааны гавьяат ажилтан Б.Дашзэвэг, Ц.Намсрай, А.Дашдаваа, Д.Дунхорол, мастер тогооч Д.Даваажав, аймгийн олон удаагийн аварга худалдагч А.Долгор, С.Наранцэцэг, Ш.Норов, Ж.Янжмаа, С.Дагийсүрэн, тогооч Б.Эрдэнэсүрэн, Л.Батмөнх, Д.Бяруузана, удирдах ажилтан, мэргэжилтэн Ц.Намсрай, Д.Гончиг, Б.Түмэнхишиг, Ж.Дүгэрсүрэн, М.Санжаа, Ө.Түвшинбаяр, Б.Шагдарсүрэн, Л.Дамдин, Н.Дэлэг, Н.Хэнмэдэх, Д.Жагаа, Ж.Нямсүрэн, Х.Дашжамц, Л.Цэрэндолгор, Б.Сэрсэнжав, Б.Ганцэцэг, Д.Батцэнгэл, Н.Гэнцэн, Ц.Дондогдулам, Ч.Дотноо зэрэг олон алдартнууд төрөн гарсан.

XVII жарны “Буян үйлдэгч” хэмээх Усан бар жилийн сар шинийн баярыг тохиолдуулан Төв аймгийн эдийн засаг, нийгэм, боловсрол, хөдөө аж ахуйн салбар, төрийн албанд болон эрхэлсэн ажилдаа хүч хөдөлмөрөө зориулж олон жил үр бүтээлтэй ажиллаж амжилт гарган, эх орныхоо хөгжил дэвшилд үнэтэй хувь нэмэр оруулж буй иргэдийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2022 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 08 дугаар Зарлигаар: “Хөдөлмөрийн гавъяаны улаан тугийн одон”-оор 9, “Алтан гадас одон”-оор 48, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар- 12, нийт 19 сумын 70 гаруй иргэд төр засагтаа хөдөлмөрөө үнэлүүлж төрийн дээд одон медалиар шагнагдсаныг 01 дүгээр сарын 31-ний өдөр “Төрийн дээд одон медаль гардуулах ёслолын үйл ажиллагаа”-г зохион байгууллаа.

Төрийн дээд одон медаль гардуулах ёслолын үйл ажиллагаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн ахлах зөвлөх С.Лүндэг, Ерөнхийлөгчийн хот, хөдөөгийн хөгжлийн бодлогын зөвлөх О.Буяннэмэх, аймгийн ИТХ-ын нарийн бичгийн дарга Ч.Жавзанпагма, аймгийн Засаг даргын орлогч Г.Сурмаа, УИХ-ын гишүүн Ж.Батжаргалын зөвлөх Б.Ганбат нар оролцлоо.

### **Хоёр. Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн хүрээнд:**

#### ***Нутгийн удирдлага, хамтын ажиллагааны хүрээнд:***

01 дүгээр сард Аймгийн Засаг даргын Зөвлөлийн хуралдаанаар үндсэн нэгж, сумын Засаг дарга, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдээс ирүүлсэн 85 иргэний тодорхойлолтыг хэлэлцүүлж, холбогдох байгууллагаас дүгнэлт авах хүсэлт явуулж Монголын ахмадын

холбооноос бусад дээд шатны байгууллагаас хариу ирүүлээгүй байна. Хариутай бичиг, өргөдлийг хугацаанд нь шийдвэрлэж хариуг хүргүүлж ажилласан.

Удирдлагын академийн 2022 оны сургалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Төрийн албанд анх томилогдсон албан хаагчийг чиглүүлэх богино хугацааны сургалтад 8 албан хаагч, дунд хугацааны сургалтад 2, дунд хугацааны давтан сургалтад 1, Ахлах түшмэлийн багц сургалтад 3 алба хаагч, Аймгийн ЗДТГ-ын даргын албан бичгээр хүргүүлж, Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтад хамрагдах 8 албан хаагчийн бүртгэл мэдээллийг удирдлагын академид хүргүүлсэн. Монгол Улсын Ерөнхий сайдтай байгуулсан Аймгийн Засаг даргын батламж гэрээний биелэлт, Шадар сайдтай байгуулсан 2021 онд хамтран ажиллах гэрээний хэрэгжилт, Монгол Улсын сайд Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын гэрээний хэрэгжилтийг гаргаж Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Шадар сайдын ажлын албанд хэвлэмэл болон файлаар цахим шуудангаар хүргүүлж ажилласан.

Аймгийн 2021 оны Хөдөлмөрийн аваргуудыг холбогдох журмын дагуу Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж батлуулан шагналыг Монгол туургатан театрт гардуулах ажлыг зохион байгуулж ажилласан.

Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар 2021 оны 08 дугаар сард зохион байгуулсан цахим засаглал шилжиж, хүнд суртал, авлигагүй, чадварлаг төрийн үйлчилгээг бүрдүүлэх үндэсний хорооны үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үүднээс төрийн албан хаагчдыг чадавхижуулах хөтөлбөрийг Төрийн албаны зөвлөл, Монгол Улсын Ерөнхий сайдын Ажлын албаны дэмжлэгтэйгээр Удирдлагын академи, Сингапурын Үндэсний Их Сургууль, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөрийн Акселератор лабтай хамтран хэрэгжүүлж байгаа “Их өгөгдөлд суурилсан бодлогын инноваци” хөтөлбөрт аймаг, сум, агентлагийн “Хөгжлийн төслийн баг”-аас 14 гишүүн сонгогдон хамрагдаж, 4 гишүүн сертификат, гарын бэлэг хүлээж авав.

Аймгийн удирдлагуудын нэгдсэн шуурхайг 1 удаа зохион байгуулж, 26 заалт бүхий үүргийг тэмдэглэлээр өгөв. Уг шуурхайг цахимаар зохион байгуулж хүний бөөгнөрөл, эрсдэл үүсгэхгүй байхад анхаарч байна.

2021 онд иргэдээс Төв аймгийн төрийн байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэлтийн мэдээг нэгтгэн аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ЗГХЭГ-т хүргүүлэв.

**2021 онд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага,  
албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдлын  
шийдвэрлэлтийн байдал  
/Өссөн дүнгээр/**

№	Нэр	Нийт	Шийдвэрлэлт				Шийдвэр-лэлтийн хувь
			Шийдвэр-лэж хариу өгсөн	Бусад байгууллага д шилжүүлсэн	Хугацаа хэтрүүлж шийдвэр-лэсэн	Хугацаа болоогүй	
1	Аймгийн ИТХ	31	24	7	0	0	100
2	Аймгийн ЗДТГ	343	322	6	0	15	95,63
3	Сумд	14559	13602	571	68	318	97,82
4	Харьяа агентлаг,	2066	1972	46	6	42	97,97

	ХЭЛТЭС						
	Нэгдсэн дүн	16999	15920	630	74	375	97,79

**2021 онд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол хэлбэрээр /Өссөн дүнгээр/**

№	Нэр	Нийт ирсэн өргөдөл, гомдол	Үүнээс				
			Бичгээр	Цахим хэлбэрээр	Утсаар	Биечлэн уулзсан	Бусад
1	Аймгийн ИТХ	31	31	0	0	0	0
2	Аймгийн ЗДТГ	343	286	39	0	18	0
3	Сумд	14559	11902	332	1314	946	65
4	Харьяа агентлаг, хэлтэс	2066	1955	89	15	7	0
	Нэгдсэн дүн	16999	14174	460	1329	971	65

**2021 онд иргэдээс Төв аймгийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд хандаж гаргасан өргөдөл гомдол агуулгаар /Өссөн дүнгээр/**

Төв аймаг	Нийт 16999 өргөдлөөс 1. Хүсэлт 16480 / 96.95% 2. Гомдол 248 / 1.46% 3. Санал 271 / 1.59% 1. Газартай холбоотой асуудлаар 4687 / 27,57% 2. Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр 2661 /15,65% 3. Ажил, тусламж хүссэн 1401 / 8,24% 4. Нийгмийн даатгалын үйлчилгээний чиглэлээр 1338 / 7,87 % 5. Халамжийн үйлчилгээний чиглэлээр 942/ 5,54%
-----------	---

“Хөгжлийн түүчээ Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-д өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн дундаж хугацааг бууруулах арга хэмжээ тусган суурь түвшинг 28 хоногтой тооцож, 2021 онд 26 хоногт хүргэхээр тусгасан. Жилийн эцсийн байдлаар энэ үзүүлэлт аймгийн ИТХ-ын Ажлын албанд 11, аймгийн ЗДТГ-т 19, Засаг дарга эрхлэх асуудлын хүрээний харьяа агентлагуудад 5-20, сумдад 5-20, 7027-1111 дугаарт ирсэн өргөдөл гомдол 14 хоногтой гарсан байна.

Коронавируст цар тахлын үед иргэдийн хөдөлгөөнийг хязгаарласан, өөр аймаг, сум, гадаадад оршин суугаа иргэдэд төрийн үйлчилгээг тасралтгүй, шуурхай хүргэх нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор утсаар болон цахимаар өргөдөл, гомдол хүлээн авах боломжийг нэмэгдүүлэх үүргийн хэрэгжилтийг хангах хүрээнд Төв аймгийн цахим хуудас (<https://tov.gov.mn/>)-аар санал хүсэлт авах боломжийг бүрдүүлсэн. Мөн Зуунмод сумын Засаг даргын Тамгын газар 09 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн сар бүрийн 20-нд “Зуунмод хот таныг сонсож байна” цахим уулзалтыг зохион байгуулж байна.

Аймгийн Засаг даргын 2021 оны нэгдсэн төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 2021 оны А/22 дугаар захирамжаар батлуулан хэрэгжилтэд хяналт тавин ажиллалаа. 2021 оны жилийн эцсийн хэрэгжилт 96.6 хувьтай байна. Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар

хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг 129 арга хэмжээтэй төлөвлөснөөс хэрэгжилт 96,34%, сургалт, семинар, зөвлөгөөний төлөвлөгөөг 57 арга хэмжээтэй төлөвлөснөөс хэрэгжилт 100%, Нээлттэй хаалганы өдөрлөгийн төлөвлөгөөг 15 арга хэмжээтэй төлөвлөснөөс хэрэгжилт 94,55%, Орон нутаг, хэлтэс агентлагуудад хийгдэх хяналт-шинжилгээ үнэлгээ, шалган туслах ажлын төлөвлөгөөг 28 арга хэмжээтэй төлөвлөснөөс хэрэгжилт 98,84%, Багийн иргэдийн нийтийн хуралд оролцох хуваарийг 7 арга хэмжээтэй төлөвлөснөөс хэрэгжилт 94%, Байнгын ажиллагаатай 24 салбар хороо, зөвлөлийн үйл ажиллагааны тайлан 88,69%-ийн хэрэгжилттэй дүгнэгдлээ.

### **Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн чиглэлээр:**

#### **Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**


1.1. Төрийн албаны зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны анхдугаар хуралдаан 01 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгуулагдаж дараах асуудлыг хэлэлцлээ.



Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс 2022 онд “Төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлж, цахим мэдээллийн санд суурилсан хүний нөөцийн удирдлагыг хэрэгжүүлэх” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаатай уялдуулан Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2022 үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилт 32 арга хэмжээтэй боловсруулж 01 дүгээр тогтоолоор баталлаа. Төлөвлөлөөг боловсруулахдаа Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүрэг, мөн зөвлөлийн 2020 оны 46 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2020-2023 оны стратеги төлөвлөгөө”, аймгийн ИТХ-ын 2020 оны 01 дүгээр тогтоолоор баталсан “Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зорилго, зорилттой уялдуулж, өмнөх оны үйл ажиллагаанаас хэрэгжилт удаашралтай зарим асуудлыг тодотгон оруулсан юм.

Монгол Улсын Үндсэн хуулийн 30 жилийн ойг тохиолдуулан Төрийн албаны тухай хуулийн 22, 23, 26, 27 дугаар зүйлд тавигдсан шаардлага нөхцөл болзлыг хангаж, төрийн албаны тусгай шалгалтад тэнцэн улмаар тухайн албан тушаалд туршилтын хугацаанд ажиллахдаа төрийн албан хаагчийн зорилго зорилт, чиг үүргээ мэргэжил, ур чадварын зохих түвшинд амжилттай гүйцэтгэж байгаа 27 албан хаагчаар “Төрийн захиргааны албан хаагчийн тангараг” өргүүлэх шийдвэрийг гаргалаа.

1.2. МУЗГ-ын 2019 оны 74 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчийн улсын нэгдсэн тоо бүртгэл хөтлөх, мэдээлэл авах журам”-ийн дагуу төрийн албаны Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцооны системийн хөтлөлтөд хяналт тавьж байна. Уг системийн шинэчлэлийн хүрээнд салбар зөвлөлөөс 10 үзүүлэлтээр хяналт тавих эрх нээгдсэн бөгөөд өнөөдрийн байдлаар Төв аймгийн хэмжээнд 4754 албан хаагч бүртгэгдээд байна. ХНУМТ-ны системд төрийн албан хаагчийн мэдээллийг тухай бүр бүрэн гүйцэт, үнэн зөв оруулахаар талаар зааварчилгаа бэлтгэн төрийн байгууллагуудад хүргүүлээ.




1.3. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2021 оны 411 дүгээр тогтоолын хэрэгжилтийг тооцож, судалгаа мэдээллийг ТАЗ-д хүргүүлээ. Коронавируст халдвар (ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль, ТАЗ-ийн 2020 оны 01 дүгээр

зөвлөмжийн хүрээнд өнгөрсөн хугацаанд 92 ажлын байранд томилгоо хийгдсэн. ТАЗ-ийн 2021 оны 411 дүгээр тогтоолын дагуу дээрх 92 томилгооноос 76 иргэнийг чөлөөлсөн бол үлдсэн 16 иргэн чөлөөлөгдөөгүй байна. (Үүнээс: 62 иргэнийг тушаалаар томилсноос 56 чөлөөлж, 6 чөлөөлөөгүй, 30 иргэнтэй гэрээ байгуулснаас 20 гэрээг цуцлаж, 10 гэрээг цуцлаагүй).

Зөрчилтэй томилгоог арилгасан болон шинээр үүссэн нийт сул орон тоо 160 байна. Үүнээс захиалга өгсөн 146 ажлын байрнаас 136 ажлын байрыг олон нийтэд зарласан бол үлдсэн 10 ажлын байр хүлээгдэж байна. Сул орон тоо гарснаас ТАТХ-д заасан хугацаанд захиалга ирүүлээгүй байгаа 14 ажлын байр байна. Эдгээр ажлын байруудад нийт 65 Түр орлон гүйцэтгэгч томилогдсон байх бөгөөд үүнээс хууль тогтоомжийн дагуу 43 иргэнийг Түр орлон гүйцэтгэгчээр, хууль тогтоомж зөрчиж 22 иргэнийг Түр орлон гүйцэтгэгчээр томилсон байна. Нутгийн захиргааны байгууллагуудаас БТСГ, ГБХЗХГ, ОНӨГ, СХДАА, СХЗХ, СХ, ТХ, УБХ, ЭМГ, Зуунмод, Лүн сумын ЗДТГ-аас зөрчилгүй гэсэн мэдээлэл өгсөн.

1.4. 2022 оны 01 дүгээр сард салбар зөвлөлийн үйл ажиллагааг үнэлэх журмын төсөлд санал өгч, Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, Ерөнхий сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан батламж, аймаг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр болон Төрийн болон албаны нууцыг хамгаалах хүрээнд зохион байгуулсан ажлын тайлан, хэрэгжилт, мэдээллийг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүллээ.

1.5. Салбар зөвлөлөөс эрх хэмжээний хүрээнд 5 тогтоол гаргасан бөгөөд дунджаар 72.2%-ийн хэрэгжилттэй байна. (100%-3, 50.0%-1, 10.0%-1)



1.6. Салбар зөвлөлд ирсэн хариутай бичиг, өргөдөл гомдол, СЗ-өөс явуулсан хариутай бичгийн шийдвэрлэлтийг 2022 оны 01 дүгээр сарын 31-ний байдлаар танилцуулбал:


№	Төрөл	Нийт тоо	Үүнээс хариутай	Шийдвэрлэсэн	Хүлээгдэж буй	Шийдвэрлэлтийн хувь
1	Ирсэн албан бичиг	47	32	13	19	40.6%
2	Ирсэн өргөдөл, гомдол	2		1	1	50.0%
3	Явсан албан бичиг	20	15	9	6	60.0%

## **2. Сургалт, мэдээллийн чиглэлээр:**

2.1. Тайлант хугацаанд ТАЗ-ийн “7:4:10” цахим сургалт 4 удаа зохион байгуулахад холбогдох албан хаагчдыг хамрууллаа. Мөн 2 удаагийн цахим хэлэлцүүлэг, уулзалтад оролцсон.

### **3. Сонгон шалгаруулалтын чиглэлээр:**

3.1. Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 14 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны тусгай шалгалт өгөх болзол, журам”-ын 2.6-д заасны дагуу төрийн захиргааны 69 (удирдах 7, гүйцэтгэх 62) сул орон тоог нөхөх тусгай шалгалтыг 1 удаа зохион байгуулсан. Шалгалтын нийлбэр дүнгээр нийт зарлагдсан ажлын байрны 21.7% нь нөхөгдөх боломжтой болж хамгийн өндөр оноотой 15 оролцогч (үүнээс эрэгтэй 4, эмэгтэй 11)-ийг тухайн албан тушаалд нэр дэвшүүлсэн.



Уг шалгалтад ТЖАХ-аас 2, ТЖАХ-ийн нөөцөөс 1, 2019 оны нөөцөөс 1, 2020 оны нөөцөөс 3, 2021 оны нөөцөөс 8 иргэн орж ажлын байраар хангагдсан.

Туслах түшмэлийн 96 сул орон тоог тусгай шалгалтаар нөхөх захиалгыг ТАЗ-д хүргүүлээд байна.

3.2. Төрийн албаны тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1.11 дэх заалт, “Төрийн үйлчилгээний байгууллагын төсвийн шууд захирагчийг сонгон шалгаруулах журам”-ын 2.3-т заасныг тус тус үндэслэн төрийн үйлчилгээний байгууллагын 9 удирдах албан тушаал (төсвийн шууд захирагч)-ын сул орон тоог нөхөх сонгон шалгаруулалтын зарыг олон нийтэд мэдээллээ. Уг шалгалтын бүртгэл 2022 оны 02 дугаар сарын 21,22-ны өдрүүдэд хийгдэж, 02 дугаар сарын 25-ны өдөр шалгалт болно.

Сонгон шалгаруулалтуудын дүн мэдээг маягтын дагуу гаргаж тухай бүр ТАЗ-ийн СШГ-т хүргүүлж байна.

### **Аймгийн Нэгдсэн үйлчилгээ, хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах алба-төрийн үйлчилгээний нэгдсэн төвийн хүрээнд:**

2022 оны 01 дүгээр сард аймгийн Төрийн үйлчилгээний нэгдсэн төвд Төрийн болон бизнесийн дэмжих үйлчилгээний нийт **17** байгууллага **430** төрлийн үйлчилгээг **10037** иргэнд, өдөрт дунджаар **450-500** иргэнд хүргэж байна. Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй ажил үйлчилгээ, арга хэмжээний талаарх мэдээллийг “Өлзий”, ТБС, Төв, Сүлд, Live телевизүүдтэй гэрээ байгуулан хамтран ажиллаж иргэд олон нийтэд хүргэж байна. Мөн Аймгийн албан ёсны веб сайт болох [www.tov.gov.mn](http://www.tov.gov.mn), “Төв аймгийн хэвлэл мэдээллийн алба” нэртэй албан ёсны пейж хуудас, албаны мэдээллийн болон урсдаг самбар, ухаалаг дэлгэц зэрэг эх сурвалжаар иргэд, олон нийтэд түгээж байгаа бөгөөд энэ сард аймгийн веб сайтад **7**, “Төв аймгийн Хэвлэл мэдээллийн алба” пэйж хуудсанд **58** мэдээ мэдээлэл тус тус нийтлэгдлээ. 7 хоног бүрийн Лхагва гаригт цацагддаг “Төв



аймгийн цаг” нэвтрүүлгийн 2 дугаарыг бэлтгэн иргэд олон нийтэд хүргэсэн. Бусад 5 төрлийн телевизүүдийн мэдээний цагаар 5 мэдээ, мэдээлэл давтагдсан тоогоор 15 удаа цацагдсан байна. Төрийн албан хаагчдын ёс зүй, сахилга хариуцлагатай холбоотой санал, гомдлыг хүлээн авдаг 7027-1111 нээлттэй утсанд 9 гомдол ирснийг холбогдох хэлтэс, агентлагуудад уламжлан шийдвэрлэлтэд хяналт тавьж ажиллаж байна. Одоогийн байдлаар хугацаа болоогүй 9 гомдол байна.

Тус төв нь Засгийн газрын 149-р тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Төрийн мэдээлэл солилцооны E-mongolia цахим системийг нэвтрүүлж 18 байгууллагын 156 төрлийн лавлагаа мэдээллээр иргэдэд үйлчилж байгаа бөгөөд E-mongolia цахим системээр дамжуулан 01 дүгээр сард аймгийн хэмжээнд 896 лавлагаа үйлчилгээг иргэдэд гарган өгч үйлчилсэн байгаагаас ТҮНТөвийн операторуудаас 152 лавлагаа үйлчилгээ авчээ. Мөн байгууллагын цахим мэдээллийн буланд байх ухаалаг дэлгэцүүдээр дамжуулан иргэдэд төрийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэж байгаа бөгөөд газрын цахим систем болох [www.egazar.gov.mn](http://www.egazar.gov.mn) сайтаар дамжуулан нийт 62 иргэн газрын талаарх үйлчилгээ авчээ.

### **Мэргэжлийн хяналтын чиглэлээр:**

Мэргэжлийн хяналтын байгууллагын “Хяналт удирдлагын нэгдсэн систем”-д давхардсан тоогоор 12298 ААН-ийн эрсдэлийг үнэлэхэд 1223 буюу 9.94 % их эрсдэлтэй, 2912 буюу 23,67% нь дунд эрсдэлтэй, 8163 буюу 66.39% нь бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

#### ***Нэг. Эрүүл мэнд, боловсрол, хүнсний чиглэлээр:***

Иргэн, аж ахуй нэгжийн өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу хийгдсэн шалгалт:

1. Улаанбаатар Төмөр замын хүүхдийн сектороос ирүүлсэн хүсэлтийн дагуу Архуст сумын Нарлаг цэцэрлэг, Баян сумын Бамбар цэцэрлэгийн хоол үйлдвэрлэл, эрүүл ахуйн нөхцөл шаардлагад нийцсэн эсэх талаар шалгалт хийж улсын байцаагчийн хамтарсан дүгнэлт 2;

2. Сэргэлэн сумын 2-р багийн (Довын гуанз) Хангай цайны газрын үйл ажиллагаа сэргээх улсын байцаагчийн акт 1;

3. Малын гоц халдварт шүлхий өвчний нөхцөл байдлын мэдээг хугацаанд нь 2 удаа хүргүүлсэн.

4. Ургамал болон ургамлын гаралтай түүхий эд бүтээгдэхүүний 3 дээжийг ургамлын эрүүл аюулгүйн үзүүлэлт нитрат, нитрит, өвчин, хортны шинжилгээнд хамруулсан.

#### ***Хоёр. Бусад:***

1. Коронавируст халдварын Омикрон хувилбарын дэгдэлтийн үеийн эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг аймгийн Эрүүл мэндийн газар, Баруун Зуунмод өрхийн эрүүл мэндийн төвийн үйл ажиллагаанд Эмчилгээний чанарын хяналтын улсын байцаагч, Эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч нар хамтран төлөвлөгөөт бус зөвлөн туслах үйлчилгээг хийж гүйцэтгэлээ. Зөвлөн туслах үйлчилгээний явцад илэрсэн зөрчлийг арилгах арга зам, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч улсын байцаагчийн хамтарсан 26 заалт бүхий 2 зөвлөмжийг хүргүүлэн ажилласан.

2. Коронавируст халдварын шинжилгээ авах цэгт 2 удаа эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөл, шаардлагыг хангуулах зорилгоор зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж зөрчил дутагдлыг арилгуулан ажилласан.

3. Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор дархлаажуулалтын цэгт 2 удаа эрүүл ахуй, халдвар хамгааллын нөхцөл, шаардлагыг хангуулах зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж зөрчил дутагдлыг арилгуулан ажилласан.



4. Зураг төсөлд эрүүл ахуйн хяналт хийлгэх тухай хүсэлтийн дагуу үйлдвэрийн, ШТС-ын барилга байгууламжийн 3 зураг төсөлд эрүүл ахуйн урьдчилсан хяналт хийж буцаасан 2, зөвшөөрсөн 1 дүгнэлт гаргасан.

5. ҮАБЗ-д манай аймгийн лабораторийн пестицидийн шинжилгээний арга, хэдэн үзүүлэлтээр ямар төрлийн шинжилгээ хийдэг талаарх судалгааг хүргүүлсэн.

6. МХЕГ-ын ХАБХААХХ-т 2019, 2020, 2021 оны тариалсан талбайн хэмжээ, хураасан ургац, ургамлын гарал үүслийн код олгох цахим систем, хүнсний ногооны одоо мөрдөгдөж байгаа стандартуудыг шинэчлэх зэрэг ажилд viber сүлжээгээр санал өгсөн.

**Хоёр. Байгаль орчин, дэд бүтэц, хөдөлмөрийн хяналтын чиглэлээр:**

**Төлөвлөгөөт бус ажил:**

**Геологи, уул уурхайн хяналтын чиглэлээр:**

Төв аймгийн Аргалант сумын нутаг дахь Батцагаан нэртэй түгээмэл тархацтай ашигт малтмалтын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайд 2021 онд хийгдсэн хайгуулын ажлын тайланг хүлээн авч хянасан. Терроризмтой тэмцэх зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах саналыг хүргүүлсэн.

**Байгаль орчин, газар, геодези зураг зүйн хяналтын чиглэлээр:**

Баянхангай сумын нутагт үр тарианы чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Кмеака ХХК-ийн үйл ажиллагааг Багийн засаг дарга, Газар зохион байгуулагч, Хэсгийн төлөөлөгч, ажлын хэсгийн бусад гишүүд шалгалтыг хийж хууль бус үйл ажиллагааг зогсоож, техник хэрэгслийг лацадсан гэх 2134000894 зөрчлийн хэрэгт зөрчил хянан шийдвэрлэх ажиллагаа явуулж Төв аймаг дахь Прокурорын газарт хүргүүлсэн.

Төв аймгийн Зуунмод сумын Байгаль орчны хяналтын улсын байцаагч нь Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт газар эзэмшдэг (хууль бусаар) иргэнд мэдэгдэх хуудас өгсөн гэх өргөдөл гомдлын дагуу хяналт хийж 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр албан бичгээр хариу хүргүүлсэн. Төв аймаг дахь Цагдаагийн газраас 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 43/4-4414 дугаар албан бичгээр харъяаллын дагуу шилжүүлэн ирүүлсэн Төв аймгийн Баянчандмань сумын Эрдэнэ 3 дугаар багийн нутаг Харганы ам гэх газар иргэн Толягийн Гантөгс (РД:НХ79090219) нь зохих зөвшөөрөлгүй мод үржүүлгийн газар ажиллуулсан гэх зөрчилд 2134000881 дугаартай хэрэг нээн шалгаж байна.

**Хөдөлмөрийн хяналтын чиглэлээр:**

Заамар суманд Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг Бүрдэл майнинг ХХК-ийн талбайд гарсан үйлдвэрлэлийн ослын мэдээллийг МХЕГ-ын холбогдох газрын дарга, ахлах байцаагч нарт яаралтай мэдээлэх хуудсын дагуу болон цахим хаягаар хүргүүлсэн. Үйлдвэрлэлийн ослыг судлан бүртгэсэн актыг хянаж байна. Аймгийн цагдаагийн газраас ирүүлсэн №4302<sup>2</sup>-4937 дугаартай хэргийн материалд ХАБЭА-н дүрэм журам зөрчсөн эсэх асуудлаар шинжээчийн дүгнэлт гарган ажиллаж байна. МХЕГ-ын Тэргүүн дэд даргын баталсан удирдамжийн хүрээнд Үйлдвэрлэлийн осол, хурц хордлогын удирдамжийн төслийг хэлтэс, газрын даргаар хянуулж батлуулахаар ажиллаж байна.

**Хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын чиглэлээр:**

Төв аймгийн Баянцагаан суманд баригдах Монголчехметалл ХХК-ийн Чулуут цагаан дэл хайлуур жонш баяжуулах үйлдвэрийн аж ахуй, усан сангийн барилгын зураг төсөлд урьдчилсан хяналт хийж ажилласан.

**Барилгын техникийн хяналтын чиглэлээр:**

Монгол Улсын Засгийн газрын 318 дугаар тогтоолын хүрээнд Төв аймгийн Нэгдсэн эмнэлгийн угаалгын барилгын ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж үүрэг даалгавар өгч ажилласан.

Төв аймгийн Сэргэлэн сумын Баянбүрд 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт баригдсан “Таван толгой түлш” ХХК-ийн зүүн бүсийн бэлэн бүтээгдэхүүний ангарагч барилга, талбайн гадна гэрэлтүүлэг, офиссын барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын

бүрэлдэхүүнд орж барилга, харилцаа холбооны хяналтын чиглэлээр үүрэг даалгавар өгч ажиллалаа.

**Харилцаа холбооны хяналтын чиглэлээр:**

Төв аймгийн Сэргэлэн сумын Баянбүрд 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт баригдсан “Таван толгой түлш” ХХК-ийн зүүн бүсийн бэлэн бүтээгдэхүүний Ангараг барилга, гадна талбайн гэрэлтүүлэг, офиссын барилга байгууламж ашиглалтад оруулах комиссын бүрэлдэхүүнд орж барилга, харилцаа холбооны хяналтын чиглэлээр үүрэг даалгавар өгч ажиллалаа.

**Гурав. Сорилтын нэгдсэн лаборатори:**

Эрүүл ахуй нян судлалын лаборатори нь төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус хяналт шалгалтын хүрээнд нийт 12 дээжинд 40 үзүүлэлт (гүний усны 7 сорьцонд 21, төвлөрсөн системийн ус 1 сорьцонд 3, савласан ус 2 сорьцонд 6, бохир ус 2 сорьцонд 10) үзүүлэлтээр эрүүл ахуй нян судлалын *шинжилгээг хийж хянаж, баталгаажуулан гаргасан.*

**Онцгой байдлын газрын хүрээнд:**

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын талаар:**

Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн 2020 оны 95 дугаар тогтоолоор Төв аймгийн Онцгой байдлын газрыг Төв аймгийн Баянчандмань сумын уугуул, Хүндэт чекист, хурандаа Жанцангийн Жанчив агсны нэрэмжит болголоо.

Монгол Улсад мэргэжлийн гал түймэртэй тэмцэх байгууллага үүсэн байгуулагдсаны түүхт 100 жилийн ойг тохиолдуулан онцгой байдлын албанд шинээр томилогдсон алба хаагчид тангараг өргөх, нийт бүрэлдэхүүн тангараг давтах ёслолын арга хэмжээг 2022 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр зохион байгууллаа.

Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2022 оны А/01 дүгээр тушаал, Онцгой байдлын газрын даргын 2022 оны А/02 дугаар тушаалын хэрэгжилтийг хангаж, 2022 оны сургуулийн жилийн нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу Онцгой байдлын газрын 2022 оны Сургуулийн жилийн нээлтийн үйл ажиллагааг Коронавируст халдварын цар тахлаас урьдчилан сэргийлэх зорилгоор халдвар хамгааллын дэглэмийг баримтлан, Мөнгөнморьт сум дахь гал түймэр унтраах, аврах 75-р анги, Лүн сум дахь эрэн хайх, аврах бүлэг, Жаргалант, Цээл, Бүрэн, Баян сум дахь Улсын нөөц хүмүүнлэгийн тусламжийн цэгийн алба хаагчдыг цахимаар хамруулан зохион байгууллаа.

**Хоёр. Сургалт сурталчилгаа, урьдчилан сэргийлэх талаарх ажил:**

Онцгой байдлын ерөнхий газраас дэвшүүлсэн зорилт, аюулт үзэгдэл, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр тухайн жилд хийж гүйцэтгэх ажлын сургалтын төлөвлөгөөтэй уялдуулан Онцгой байдлын ерөнхий газрын даргын А/133 дугаар тушаалаар шинэчлэгдэн батлагдсан “Гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөлт, гамшгаас хамгаалах ангиллын сургалт, олон нийттэй харилцах арга хэмжээ, алба сурталчлах ажлыг эрчимжүүлэн, Онцгой байдлын газрын гамшгаас урьдчилан сэргийлэх ажлын үндсэн чиглэл, дундаж үзүүлэлтийг тогтоох, үр дүнг тооцох” тухай тушаалын үүргийн хэрэгжилтийг хангах чиглэлээр аймгийн 2022 оны нэгдсэн төлөвлөгөөнд гамшгаас хамгаалах ангиллын сургалтын хуваарийг оруулан аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлэн ажилласан.

Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх газарт Онцгой байдлын газраас зохион байгуулж буй ангиллын сургалтын СМ-1 мэдээ, урьдчилан сэргийлэх ажлын тоон үзүүлэлтийг цахим хаягт байршуулахаас гадна 7 хоног бүрийн баасан гаригт цаасан хэлбэрээр хүргүүлэн ажиллаж байна.

Аюулт үзэгдэл, ослын төрөл тус бүрт урьдчилан сэргийлэх, аврах, хор уршгийг арилгах талаар онол, практикийн мэдлэг, чадвартай алба хаагчдыг бэлтгэх зорилгоор ангиллын сургалт зохион байгуулах удирдамж гарган батлуулж, Онцгой байдлын газрын урьдчилан сэргийлэх тасгийн алба хаагчид, мэргэжилтэн нартаа хамтран ангиллын сургалтыг танхим болон цахим хэлбэрээр зохион байгуулж 3 удаагийн 8 цагийн сургалтаар 110 ажилтныг хамрууллаа.

Үүнд:

- УБЦТС ТӨХК-ны Зуунмод сум дахь хэрэглэгчдэд үйлчлэх төвийн нийт 39 ажилчдад “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”, “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах”, “Мал, амьтны гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх” чиглэлээр нийт 3 цагийн сургалтыг танхим хэлбэрээр зохион байгуулж холбогдох хууль тогтоомжийг сурталчлан ажилласан.

- Төв аймгийн Сэргэлэн сумын нутаг дэвсгэрт олон төрлийн түлш түгээх станцын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг “Газ Ойл Нефт ХХК”-ны нийт 15 ажилчдад “Гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, бэлэн байдлаа хангах”, “Гамшгийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-аар 2 цагийн танхимын сургалтыг зохион байгуулсан.

- УБЦТС ТӨХК-ны Зуунмод түгээх төвийн нийт 56 ажилчдад “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Гамшгаас хамгаалах төлөвлөгөө боловсруулах заавар”-аар цахим сургалт зохион байгуулсан.

Гал унтраах өдөр тутмын дасгал сургуулийг Онцгой байдлын газрын даргаар батлуулж батлагдсан төлөвлөгөөний дагуу 24 удаа 48 цагийн дадлагыг давхардсан тоогоор 168 алба хагчийг хамруулан зохион байгуулж мэргэжлийн ур чадвар авхаалж самбааг дээшлүүлэн ажиллаж байна.

#### **Гурав. Улсын хяналтын чиглэлээр:**

Төв аймгийн Онцгой байдлын газраас гамшиг, осол гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр дараах ажлуудыг хийж гүйцэтгэв:

Шалгалтад Төв аймгийн хэмжээнд Худалдаа олон нийт, үзвэр үйлчилгээний 6 байгууллага хамрагдсанаас гал түймэр, гамшиг ослын аюулд хүргэж болзошгүй 31 зөрчил илэрснээс газар дээр нь 12 зөрчлийг арилгуулж 19 зөрчилд хугацаат үүрэг даалгавар, ЗБАШ-4-г бичиж тухайн байгууллагуудад хүргүүлэн, хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулах талаар зөвлөн туслах арга хэмжээг зохион байгуулж сургалт, заавар зөвлөгөө өгсөн.

Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус шалгалтаар нийт 36 байгууллага, аж ахуй нэгжийг шалгаж гамшиг осол болон гал түймэр гарч болзошгүй 142-н зөрчил дутагдлыг илрүүлж газар дээр нь 78 зөрчил арилгуулан холбогдох аж ахуйн нэгж, байгууллагын, албан тушаалтанд заавар зөвлөгөөг өгч ажилласан байна. Аймгийн хэмжээнд баригдах 10 барилгын зураг төслийг хянаж, дүгнэлт бичиж холбогдох дансанд зураг хяналтын 1,150,000 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Барилга байгууламж шинээр ашиглалтад оруулах байнгын ашиглалтад авах улсын комисст 4 удаа орж ажиллалаа. Хяналт шалгалтанд хамрагдаж, галын аюулгүй байдал нь хангагдсан 26 аж ахуй нэгж байгууллагад ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт, зөвшөөрөл олгосон.

Аймгийн шуурхай штаб 10 удаа 240 цагийн үүрэг гүйцэтгэж үүрэг гүйцэтгэх хугацаанд иргэдээс ирсэн мэдээ, мэдээллийг цаг тухай бүрт шийдвэрлэж, хойд бүсийн төвд мэдээ тайланг явуулсан.

#### **Тохиолдсон гал түймрийн талаар.**

##### **Объектын гал:**

2022 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр Баянжаргалан сумын Жаргалант багийн Баясгалантын 6-604 тоотод оршин суух иргэн Б.Отгонбаатарын эзэмшлийн 5 ханатай гэр эд зүйлийн хамт шатсаныг нутгийн 45 иргэн 11 техник хэрэгсэлтэй бүрэн унтраасан байна.

**Мал амьтны гоц халдварт өвчин:**

Заамар сумын 2-р багийн нутаг Төмстэй, 1-р баг Тосон, 4-р баг Цайдам хар нуур гэх газруудад гоц халдварт шүлхий өвчний хорио цээрийн дэглэм Сумын засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 24-ний А/08 тоот захирамжаар цуцлагдсан. Лүн сумын 2-р багийн нутаг Долоон давааны өр, 1-р баг Цэгээн нуур, Зүүн сэртэн, Оорцог гэх газруудад гоц халдварт шүлхий өвчний хорио цээрийн дэглэм Сумын засаг даргын 2022 оны 01 дүгээр сарын 23-ний А/16 тоот захирамжаар цуцлагдсан.

Сүмбэр сумын 2-р багийн нутаг Туудан гэх газар мал амьтны шүлхий өвчний хорио цээрийн дэглэм Сумын засаг даргын 2022 оны 01 сарын 27-ны А/11 тоот захирамжаар цуцлагдсан. Баяндэлгэр сумын 2-р багийн нутаг Тахилтын ам гэх газар үйл ажиллагаа явуулдаг "Friendship" фермийн 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр дуудлага өгсний дагуу нэгжийн эмч үзлэг хийн дээж авч аймгийн МЭАЦТЛ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 04-ний өдөр гоц халдварт шүлхий өвчин болох нь оношлогдсон. Голомт болон сэжигтэй бүсийн 39 үхрийг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна. Голомтод 4 үхэр өвчилсөн. Голомтын бүсийг 5 км-ээр тогтоож, 2 албан хаагч суурин 1 постонд үүрэг гүйцэтгэж байна.

Сэргэлэн сумын 5-р багийн нутаг Ар шаварт гэх газар өвөлжиж байгаа Б.Бямбасайхан, А.Наранцэцэг нарын 2 өрхөөс 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдөр дуудлага өгсний дагуу нэгжийн эмч үзлэг хийн дээж авч аймгийн МЭАЦТЛ-ийн 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр гоц халдварт шүлхий өвчин болох нь оношлогдсон. Голомт болон сэжигтэй бүсийн 96 үхэр, 1669 хонь, 410 ямааг шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамруулах ажлыг зохион байгуулж байна. Голомтод 2 айлийн 4 үхэр, 120 хонь өвчилсөн. Голомтын бүсийг 10 км-ээр тогтоож, 5 албан хаагч суурин 1, хөдөлгөөнт 1 постонд үүрэг гүйцэтгэж байна.

**Авто осол:**

Баянхангай сум Хөшөөт багийн Айргийн үзүүр гэдэг газарт Улаанбаатар хотоос Баянхонгор аймгийн чиглэлд зорчиж явсан 07-62БНА улсын дугаартай "Приус-20" загварын автомашин, Улаанбаатар хотын чиглэлд зорчиж явсан 51-69 УНР улсын дугаартай "Субару-форестер" автомашинтай мөргөлдөж "Субару-форестер" загварын автомашин дотор хүн хавчуулагдсан тухай дуудлагаар Лүн сум дахь Эрэн хайх, аврах бүлгийн 3 алба хаагч, 1 автомашинтай 46 километр замыг туулан 16:23 цагт дуудлагын газар очиж автомашинд хавчуулагдаж нас барсан иргэнийг 30 минут ажиллан 17:05 цагт буцалтгүй нэрвэгдэгчийг гаргаж Лүн сумын замын цагдаа, дэслэгч М.Энхманлайд шилжүүлж өгсөн.

Лүн сумын Цагаан хөтөл гэх газарт Улаанбаатар хотоос Баянхонгор аймгийн чиглэлд зорчиж явсан 16-61 БНА улсын дугаартай автобус Өвөрхангай аймгаас Улаанбаатар хотын чиглэлд зорчиж явсан 16-87 ӨВЕ улсын дугаартай Санато пи автомашинтай мөргөлдөж Санато пи загварын автомашин дотор хүн хавчуулагдаж нас барсан тухай дуудлагаар Лүн сум дахь Эрэн хайх, аврах бүлгийн дарга дэслэгч Б.Мөнхбаяраар ахлуулсан 1 алба хаагч, 1 автомашинтай 10 километр замыг туулан 23:10 цагт дуудлагын газар очиж Санато пи загварын автомашинд хавчуулагдаж нас барсан иргэнийг 1 цаг 50 минут ажиллан 01:00 цагт буцалтгүй нэрвэгдэгчийг гаргаж Лүн сумын замын цагдаа, дэслэгч М.Энхманлайд шилжүүлж өгсөн.

**Дөрөв. Хэвлэл мэдээллмйэ хэрэгслээр сургалт, сурталчилгээ явуулсан байдал:**

Аймгийн ТБС телевизтэй хамтран ажиллах гэрээг 1 жилийн хугацаанд байгуулж цаг агаарын сэрэмжлүүлэх шторк, ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлэх шторк, коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зөвлөмж мэдээллүүд бэлтгэн хүргэхээс

гадна “Онцгой байдлын цаг” нэвтрүүлгийн 2022 оны 01 дүгээр сарын дугаарыг бэлтгэн хүргэхээр төлөвлөгөөг батлуулан ажилласан.

Орон нутгийн TBS телевизээр цаг агаарын хүндрэлтэй нөхцөл байдал үүссэн үед хол замд зорчихгүй байх, бэлтгэл бэлэн байдлаа сайтар хангах, дулаан хувцаслах, баталгаат зам гүүр, маршрутаар явах, Онцгой байдлын байгууллагаас өгч буй заавар зөвлөмжийг хэрэгжүүлэх сэрэмжлүүлэг мэдээллийг цаг тухай бүр телевизээр дамжуулан ард иргэдэд өдрийн 3 удаагийн давтамжтайгаар нийт 75 удаа хүргэн ажилласан.

Бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэрт нь цоожлон үлдээхгүй байх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлж гэр, орон сууцны цахилгааны аюулгүй байдлыг хангаж, үр хүүхдийнхээ аюулгүй орчинг цаг ямагт бүрдүүлж байх чиглэлээр “Ахуйн хүрээний ослоос урьдчилан сэргийлье” сэрэмжлүүлэх мэдээллийг бэлтгэж, TBS телевизээр ард иргэдэд өдрийн 4 удаагийн давтамжтайгаар нийт 100 удаа хүргэн ажилласан.

Монгол Улсад Гал түймэртэй тэмцэх байгууллага үүсэн байгуулагдсаны 100 жилийн ой, Онцгой байдлын газрыг Сүхбаатарын одонт, хүндэт чекист хурандаа Ж.Жанчивын нэрэмжит болгосон тухай мэдээллийг бэлтгэн Монголын Үндэсний олон нийтийн телевизийн Цагийн хүрд мэдээллийн хөтөлбөрөөр нэвтрүүлсэн.

Онцгой байдлын газрын 5200 дагагчтай фейсбүүк хуудсанд 13 удаагийн мэдээ мэдээлэл байршуулж, веб сайтад сэрэмжлүүлэг мэдээг 2 удаа, иргэдэд чиглэсэн зөвлөгөө зөвлөмжийг 2 удаа, байгууллагын үйл ажиллагаа, сургалт, хяналт шалгалт явуулсан талаарх мэдээ мэдээллийг 7 удаа нийт 11 удаагийн мэдээ мэдээллийг байршуулан иргэдийг мэдээ мэдээллээр хангаж ажиллалаа.

Байгууллагаас зохион байгуулж буй арга хэмжээний постер, бичлэгүүдийг цаг тухай бүр хийн нийт 4 төрлийн постер 2 төрлийн видео бичлэгийг цахим сайтад байршуулсан.

### **Гурав. Хууль эрх зүйн хэлтсийн хүрээнд:**

#### **Удирдлага зохион байгуулалтын хүрээнд:**

Үндсэн хуулийн 30 жилийн ойг тохиолдуулан аймгийн хэмжээнд сургалт, нөлөөллийн ажлын төлөвлөгөө гаргаж уралдаан тэмцээн 18 төрөл, цахим сургалт 12 удаа, танхимын сургалт 42 удаа, ёслол хүндэтгэлийн арга хэмжээ 18, онлайн сурталчилгааны материал 45 төрлийг тус тус хийж олон нийтэд түгээсэн байна. Телевизийн нэвтрүүлэг 8 удаа, подкаст ярилцлага 8 удаа тус тус зохион байгууллаа. Аймаг, сум, байгууллагуудын эрх бүхий албан тушаалтнуудын 62 шийдвэр, 3 гэрээний төслийн хууль зүйн үндэслэлийг хянаж, эрх зүйн асуудлаар 71 хүнд хууль зүйн зөвлөгөө өглөө.

Шинэчилсэн Хөдөлмөрийн тухай хууль, ЗЗНДНТУТ хуулийн сэдвээр 27 сумын Эрүүл мэндийн төв, Аргалант сумын төрийн байгууллагууд, БТСГ, СХЗХ, ЭМГ, Нэгдсэн эмнэлэг зэрэг байгууллагуудад онлайн болон танхимын сургалт зохион байгуулж нийт 535 хүнийг хамрууллаа. Хууль, зүйн салбарын 2021 оны онцлох ажил, үйл ажиллагааны тайланг шторкоор бэлтгэн олон нийтэд сурталчиллаа.

Хууль зүй, дотоод хэргийн сайд, Төв аймгийн Засаг даргатай 2022 онд “Хамтран ажиллах гэрээ”-нд санал хүргүүллээ. Аймгийн 2022 оны нэгдсэн төлөвлөгөөнд Хууль зүйн салбарын хүрээнд хэрэгжүүлэх ажил, арга хэмжээг тусгууллаа.

Аймгийн хэмжээнд 2021 оны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах 351 албан тушаалтны нэрсийн жагсаалтыг Авлигатай тэмцэх газарт хүргүүллээ. 2021 оны хувийн ашиг сонирхол болон хөрөнгө орлогын мэдүүлгийн бүрдүүлэлт 60 хувийн гүйцэтгэлтэй явагдаж байна.

Авлигатай тэмцэх газрын Мөрдөх шалгах хэлтсээс ирүүлсэн мөрдөгчийн 7 мэдэгдэлд хариу өгч, тайланг хүргүүллээ.

Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, байгууллагын албан хэрэг хөтлөлтийн журам, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулахад анхаарах асуудлаар 27 сум, 68 төсөвт байгууллагуудын архив, бичиг хэргийн ажилтнуудтай ажил хэргийн уулзалтыг зохион байгууллаа.

Аймгийн Прокурорын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Борнуур сумын цэцэрлэг, Шуудан холбооны газар, Заамар сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлээ.

Лүн, Сэргэлэн, Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газарт нотариатын эрх олгуулахаар Хууль, зүй дотоод хэргийн яаманд хүсэлт уламжиллаа.

Хэрэглэгчийн эрхийг хамгаалах чиглэлээр өргөн хэрэглээний 18 нэр төрлийн барааны үнийн судалгааг өмнө сарын үнэтэй харьцуулан гаргаж аймгийн Засаг даргад танилцууллаа.

Терроризмтой тэмцэх зөвлөлийн Төв аймаг дахь салбар зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд холбогдох саналыг хүргүүлээ.

Аймгийн нутаг дэвсгэрт албан болон хувийн хэргээр 12 улсын 170 гадаадын иргэн (хөдөлмөр эрхэлж буй 133, хувийн хэргээр 20, түр ирэгч 3, хөрөнгө оруулагч 11) оршин сууж байна. Хувийн хэргээр оршин суух хугацаа сунгуулах хүсэлт ирүүлсэн Шведийн Вант улсын иргэний баримт бичигт шалгалт хийж дүгнэлт гарган Гадаадын иргэн харьяатын газарт хүргүүлээ.

#### **Төрийн архивын тасгийн дотоод үйл ажиллагаа:**

Төрийн архивын эх баримтаас байгууллага, иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу 135 иргэний хүсэлтийг хүлээн авч 718 хуулбар хувь, 55 лавлагаа, 162 сан хөмрөгийн 636 хадгаламжийн нэгжийн баримтыг ашиглан үйлчилгээ үзүүлж орон нутгийн төсөвт 736.0 мянган төгрөгийг орууллаа.

9 хөмрөгийн 112 хадгаламжийн нэгжийн 1470 хуудас баримтыг скайнердаж 9054 хуудас баримтыг өгөгдлийн сантай холбон цахим бааз үүсгэлээ.

Төрийн архивт нөхөн бүрдүүлэлтээр “Монгол туурагтан театр” ХН№118 2006-2013 оны 8 хадгаламжийн нэгж, “Аймгийн Музей” ХН№92 2000-2013 оны 14 хадгаламжийн нэгжийг хүлээн авч хадгаламжийн санд бүртгэлээ.

#### **Улсын бүртгэлийн чиглэлээр:**

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр цахим санд нийт 60,716 хувийн хэрэг байгаагаас газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн 11,094 газар өмчлөх эрхийн 50,089 байна. Нийт хүлээн авсан мэдүүлэг 1057 (01 дүгээр сард хүлээн авсан мэдүүлэг 1057)

Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хууль болон Засгийн газрын 2010 оны 237 дугаар тогтоолын дагуу үйлчилгээний хураамжийн орлогоос нийт 7.5 сая төгрөг, үл хөдлөх эд хөрөнгө худалдан борлуулсны 27.8 сая төгрөг, тэмдэгтийн хураамжаас 2.3 сая төгрөгийг улсын төсөвт орууллаа.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 87 аж ахуй нэгж байгууллага бүртгүүлснээс 58 нэмэлт өөрчлөлт, шинээр 27 хуулийн этгээд үүсэн байгуулагдаж татан буугдсан хуулийн этгээд 0, үүсгэн байгуулагч өөрчлөгдсөн 4 бүртгэл хийгдсэн.

Хуулийн этгээдийн бүртгэлийн мэдээллийн сангаас иргэн, аж ахуйн нэгж байгууллагад 2 лавлагаа, хууль хяналтын байгууллагад 9 лавлагаа өгч орон нутгийн төсөвт 1.7 сая төгрөгийг орууллаа.

#### **Цагдаагийн газрын үйл ажиллагааны чиглэлээр:**

Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд 2022 оны 01 дүгээр сарын байдлаар 76 гэмт хэрэг бүртгэгдэн шалгагдаж, гэмт хэргийн илрүүлэлт 8.7 хувьтай байна.

**Эрүүлжүүлэх, саатуулах, баривчлах байрны үйл ажиллагаа:**

Гудамж талбай, олон нийтийн газар, ахуйн хүрээндээ архидан согтуурч бусдын амгалан тайван байдлыг алдагдуулж, жижгээр танхайрсан, согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон, өөрийгөө удирдан биеэ авч явах чадваргүй зэрэг зөрчил гаргасан 22 иргэнийг эрүүлжүүлж, Төв аймгийн эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээр 7-30 хоногийн хугацаагаар баривчлагдсан 50 албадан саатуулагдсан 4, ар гэрт нь хүлээлгэн өгсөн 5 нийт 81 иргэнийг эрүүл мэндийн үзлэг хийж эрүүлжүүлэх саатуулах байранд хүлээн авч ажиллалаа.

**Хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах чиглэлээр:**

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний дүрмийг зөрчиж согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 121 жолоочийг илрүүлж 95 жолоочид тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг 1 жилийн хугацаагаар хасаж, 400 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торголоо. Тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй үедээ согтууруулах ундааны зүйл хэрэглэж тээврийн хэрэгсэл жолоодож хөдөлгөөнд оролцсон 26 иргэнийг сум дундын эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн шийтгэврээр баривчлуулж, хуулийн хэрэгжилтийг хангууллаа.

**Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагааны чиглэлээр:**

Криминалистикийн шинжилгээ-31, магадлан шинжилгээ-42, хэргийн газрын үзлэгт оролцсон тоо 70, хэргийн газрын үзлэгээр илрүүлсэн ул мөр 236, гарын хээний санг баяжуулсан 111, гэмтлийн зэрэг тогтоосон дүгнэлт 111 гаргаж ажиллалаа. ДНК-ийн мэдээллийн сангийн баяжилтыг 42 нэмэгдүүлнэ. Гистологийн шинжилгээ-35 хийгдсэн.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын үйл ажиллагааны чиглэлээр:**

Гүйцэтгэлийн н бодит биелэлт	Оны эхний үлдэгдэл	Шинээр нэмэгдсэн	Хасагдсан	Биелүүлбэл зохиох	Бодитой биелүүлсэн	Үлдэгдэл	Дундаж хувь
01 дүгээр сард	217	91	3	305	39	266	12.8
	4587209.8	490354.6	131567.3	4945997.1	262845.7	4683151.4	

**Дөрөв. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хүрээнд:**

**Нэг. Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны чиглэлээр:**

**1.1 Хөрөнгө оруулалт:**

Аймгийн хэмжээнд 2022 онд **113.4 тэрбум** төгрөгийн хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ, бүтээн байгуулалтын ажил гүйцэтгэхээр төлөвлөгдлөө. Үүнд:

- Улсын хөрөнгө оруулалтаар хэрэгжих 91,0 тэрбум төгрөгөөр санхүүжих 37 төсөл, арга хэмжээ тусгагдаж 21 төсөл арга хэмжээний эрх шилжиж ирээд байна.
- Орон нутгийн хөгжлийн сангаар 6,2 тэрбум төгрөгийн 39 төсөл, арга хэмжээ
- Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 7,5 тэрбум төгрөгийн 33 төсөл, арга хэмжээ



- Орон нутгийн замын сангийн хөрөнгө оруулалтаар 1,0 тэрбум төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ
- Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлын 0,7 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий 12 төсөл, арга хэмжээ
- 27 суманд 7,0 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт тус тусгагдлаа.

### **1.2.Худалдан авах ажиллагааны талаар зохион явуулсан ажил:**

Аймгийн 2022 оны төсөв батлагдсантай холбоотойгоор аймгийн Төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлуулж, худалдан авах ажиллагааны цахим систем [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) сайтад төлөвлөгөөг нийтлэн, Монгол Улсын Сангийн ямаар батлуулсан. 2022 оны худалдан авах ажиллагааны тендер шалгаруулалтыг цахим системээр зохион байгуулахад бэлэн болсон.

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2021 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн А/772 дугаар захирамжаар батлуулж төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэн цахим тендер шалгаруулалтын [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) системээр батлуулж тендер шалгаруулалт зохион байгуулах эрхийг авсан. Батлагдсан төлөвлөгөөг олон нийтэд ил тод болгох ажлын хүрээнд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn), [www.tov.gov.mn](http://www.tov.gov.mn), [www.khural.mn](http://www.khural.mn) сайтуудад байршуулан ажилласан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 55,0 тэрбум төгрөгийн 92 төсөл, арга хэмжээг тусган баталж үүнээс тендер шалгаруулалт зохион байгуулахаар 54,9 тэрбум төгрөгийн 81 төсөл, арга хэмжээг баталсан. 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах зорилтын хүрээнд дараах төсөл, арга хэмжээний тендерийг зарласан. Үүнд:

#### **Тендер нь зарлагдсан төсөл, арга хэмжээ:**

Баруун чиглэлд авто замаас Аргалант сумын төв хүртэлх авто зам 7.1 км зам угсралтын ажил, Нээлтийг 2022.02.21-нд;

1. Дотуур байрны барилга 160 ор, Төв, Зуунмод сум. Нээлтийг 2022.02.23
2. Цэцэрлэгийн барилга 150 ор, Төв, Жаргалант сум. Нээлтийг 2022.03.02
3. Дотуур байрны барилга 160 ор, Төв, Бүрэн сум. Нээлтийг 2022.03.02

### ***Хоёр. Барилга хот байгуулалтын чиглэлээр:***

#### **2.1. Хот байгуулалтын чиглэлээр:**

Аймгийн хэмжээнд 2021 онд хийгдсэн болон 2022 онд хийгдэх ажлын төлөвлөгөөг гарган холбогдох газруудад хүргүүлж ажиллалаа. Үүнд:

"Аймаг нийслэлийн ерөнхий архитекторын дүрэм"-ийн дагуу аймгийн ерөнхий архитекторын тайланг 2022.01.14-ны өдрийн 07/41 тоотойр ГЗБГЗЗГ-т хүргүүлж тайлагналаа. Зам тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 101 дүгээр тушаалаар батлагдсан БД-82-104-10 нийтийн зориулалттай нийт талбай нь 1000 м2-с дээш орон сууцны барилгын ажилд шаардагдах гол нэр төрлийн барилгын материалын орц барилгын дүрэм болон холбогдох аргачлалуудыг үндэслэн хавсралтад дурьдсан маягтын дагуу судалгааг гарган ГЗБГЗЗГ-т хүргүүллээ.

#### **2.2. Барилга байгууламжийн эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл ашиглалтад оруулах үйл ажиллагааны чиглэлээр:**

Аймгийн хэмжээнд шинээр ашиглалтад орсон нийтийн зориулалттай болон амины орон сууцны барилгын судалгаа мэдээллийг нэгтгэж Барилгын хөгжлийн төвд хүргүүлсэн. Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайдын 2010 оны 402 дугаар тушаалаар батлагдсан "Хот тосгоны ерөнхий төлөвлөгөөний жижүүрийн хөтлөлт хийх үлгэрчилсэн заавар"-ын дагуу 2021 онд хийгдсэн жижүүрийн хөтлөлтийн тайланг хэвлэмэл болон тоон

байдлаар гарган Барилга хот байгуулалтын яаманд 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 07/33 тоот албан бичгээр хүргүүлсэн.

### ***Гурав. Газрын харилцааны чиглэлээр:***

**3.1. Газрын төлбөр:** 2021 оны газрын төлбөрийн ГТ-8 тайланг 27 сумаас авч нэгтгэн ГЗБГЗЗГазарт хүргүүлсэн. Газрын төсөл сонгон шалгаруулах зарыг [www.mle.mn](http://www.mle.mn) сайтад Зуунмод 4, Баянжаргалан 1 нийт 4 төсөл сонгон шалгаруулалтыг баталгаажуулсан. Аймгийн ИТХ-аар “Газрын төлбөрийг шинэчлэн тогтоох тухай” тогтоолын төслийн танилцуулга, мэдээллийг бэлтгэж байна.

**3.2. Газар зохион байгуулалтын чиглэлээр:** Засгийн газрын 307 дугаар тогтоолоор улсын тусгай хэрэгцээнд авсан газартай давхцалтай байгаа нэгж талбарын хувийн хэрэг, холбогдох материалын жагсаалтыг гаргаж, БХБСайдын 2021 оны 270 дугаар тушаалаар байгуулагдсан ажлын хэсэгт хүлээлгэн өгөх ажлыг 2022 оны 01 дүгээр сарын 11-14-ны өдрүүдэд Сэргэлэн сумын иргэн, хуулийн этгээдийн 1277 нэгж талбарыг ялгаж, судалгааг гаргасан.

2022 оны сумдын Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг газар зохион байгуулалтын цахимд системд 22 сумын мэдээллийг баталгаажуулсан.

**3.3. Геодези, зураг зүйн ажлын чиглэлээр:** Баянчандмань сумын Эрдэнэ 3 дугаар багийн Харганы аманд оршин суугч иргэн Т.Гантөгсийн эзэмшил газарт хяналтын хэмжилт хийж хэмжилтийн үр дүнг Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлсэн. Төв аймгийн цагдаагийн газраас ирүүлсэн 3 албан бичгийн дагуу лавлагааг гарган хүргүүлсэн. Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн албан бичгээр ирсэн түгээмэл тархацтай ашигт малтмалын зориулалтаар өргөдөл өгсөн 5 талбайд шүүлт хийж хариуг хүргүүлсэн. Баянцагаан сумын төвийн цахилгааны шинэчлэлт 7313 метр, Сэргэлэн сум Зүүндэлгэрийн 482 метр цахилгаан, Зуунмод сум 303 дугаар байр, Эрдэнэ сум Б.Өлзийбаатарын гадна цахилгаан хангамжийн гүйцэтгэлийн зургийг хүлээн авч хот байгуулалт шугам сүлжээний мэдээллийн санд оруулсан.

### ***Дөрөв. Орон нутгийн өмчийн чиглэлээр:***

#### **4.1. Өмчийн хүрээнд:**

“Төв Чандмань” ДЭХГ, БЗОСК зэрэг орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газруудын Удирдах зөвлөлийг хуралдуулж, 2021 оны гүйцэтгэлийн тайланг хэлэлцэж, 2022 оны ажлын төлөвлөгөөг баталлаа.

Төв аймгийн 25 суманд дулаан үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаа эрхэлж буй аж ахуйн нэгжүүдтэй байгуулсан гэрээний хэрэгжилт, цаашид анхаарах асуудал сэдвээр уулзалтыг 2022 оны 01дүгээр сарын 13-ны өдөр зохион байгуулж, сумдад дулаан үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхлэж буй ААН, удирдлагууд болон сумдын Засаг дарга нартай биечлэн уулзаж, 2022 оны ажлын төлөвлөгөөг баталгаажуулан мөрдөн ажиллах, сумын Засаг дарга нарт дулаан үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагын удирдлагуудын хугацаа дууссан болон шинээр байгуулах үүрэг даалгавар өглөө.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын шийдвэрээр орон нутгийн өмчийн хөрөнгийг худалдах, акталж устгах, шилжүүлэхээр шийдвэрлэсэн тогтоолын хэрэгжилтийг гарган Төрийн аудитын газарт тайлагнасан.

Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлын 2021 оны 62 тоот тогтоолоор дуудлагын худалдаагаар худалдахаар шийдвэрлэсэн Батсүмбэр сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 2 барилгын дуудлагын худалдааг олон нийтэд нээлттэй зарлан явуулахад оролцогч ирээгүй тул дуудлагын худалдааг дахин зарласан.

Баянцогт сумын цэцэрлэг, Ерөнхий боловсролын сургууль, ЗДТГазар болон ИТХ-ын ажлын албаны элэгдлээрээ анхны өртөгөө нөхсөн тэг төгрөгийн үлдэгдэл өртөгтэй хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг 2019 оны 271 дүгээр тогтоолын дагуу хөрөнгийг судлаж үнийг шинэчлэн тогтоож, ашиглах жилийг сунгасан.

**4.2. Түрээсийн орон сууцны хүрээнд:** Аймгийн “Түрээсийн орон сууц” хөтөлбөрийн хүрээнд сан бүрдүүлж, зорилтот бүлгийн иргэдийг түрээсийн орон сууцанд хамруулах журам”-ыг хэрэгжүүлж, нийт 25 өрхийг түрээсийн орон сууцанд хамруулж, сарын төлбөрийг график, хугацааны төлөлтөд хяналт тавьж ажилласнаар 2021 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар түрээсийн төлбөр 46,570.310 төгрөгийг түрээсийн орон сууцны санд төвлөрүүлээ.

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан “Түрээсийн орон сууц” хөтөлбөрт 800.0 сая төгрөг, “Төрийн албан хаагчдыг орон сууцаар хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр 700.0 сая төгрөг нийт аймгийн төсөвт 1.5 тэрбум төгрөг тусгаж, орон сууцыг барих тооцоо судалгааг гаргаж байна.

### ***Тав. Хөдөө аж ахуйн чиглэлээр:***

#### **5.1. Мал аж ахуйн хүрээнд:**

Аймгийн аварга малчин шалгаруулах журам хангасан материалыг нэгтгэн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн “Аймгийн хошой аварга малчин” 5, “Аварга малчин” 69, “Ж.Самбуугийн нэрэмжит залуу аварга малчин” 21, “Алтан төлийн эзэн” 10, “Аварга фермер” 3, “Аварга саальчин” 5, “Аварга хадланч” 5 тус тус шалгарууллаа. Мал тооллогын дүнд шинээр 1000 толгой мал тоолуулсан 25 сумын 126 малчдын мэдээллийг нэгтгэлээ.

#### **5.2. Мал эмнэлгийн үйлчилгээний хүрээнд:**

“Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ”, “Шимэгчтэх өвчнөөс эмчлэн сэргийлэх арга хэмжээ”-ний нэгдсэн төлөвлөгөөг тус тус боловсрууллаа. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө, 4 нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, 41 албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулан цахим санд оруулсан. Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нийцүүлэн Мал эмнэлгийн аж ахуй нэгж, иргэнээс санхүүжих үйл ажиллагааны зардлыг 7 сум шинэчлэн батлууллаа.

Мөн “Мал эмнэлгийн салбарын ажилтны зөвлөгөөн”-ийг зохион байгуулж 119 малын эмч, мэргэжилтэн хамрагдлаа.

Нийт 1439 мал, амьтан, 191.4 тн мах, махан бүтээгдэхүүн, 4946 ширхэг арьс шир, 874.1 тн сүү, сүүн бүтээгдэхүүн, 2.8 сая ширхэг өндөг, 7287 кг дайвар бүтээгдэхүүнд 2226 мал эмнэлгийн гэрчилгээг олгосон. Лүн суман дахь Мал эмнэлгийн хорио цээрийн хяналтын цэг нь 3 ээлжээр 24 цагт малын шилжилт хөдөлгөөн, тээврийн хэрэгсэлд хяналт шалгалт хийж, мал амьтан тэдгээрийн гаралтай түүхий эд бүтээгдэхүүн тээвэрлэн явж байгаа 134 тээврийн хэрэгсэл, үхэр 41, адуу 24, хонь 108, ямаа 98 нийт 265 толгой мал, мах, махан бүтээгдэхүүн 491 тн, 54629 ширхэг арьс шир, 22,5 тн дайвар бүтээгдэхүүн болон 12,6 тн цагаан идээнд эрүүл ахуйн үзлэг хийн, мал эмнэлгийн гэрчилгээнд хяналт шалгалт хийлээ.

#### **5.3. Газар тариалангийн хүрээнд:**

“Аймгийн жимс, жимсгэнэ үндэсний хөтөлбөр”-ийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Аймгийн засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж 90 хувьтай дүгнэгдлээ. 2022 оны хаврын тариалалтад дутагдах улаанбуудайн 3167.72 тн үрийн захиалгыг (9 сумын 69 аж ахуйн нэгжийн) хүсэлтийг ХХААХҮЯаманд хүргүүлэх ажлыг зохион байгууллаа.

Газар тариалангийн салбарын Хөдөлмөрийн баатар Цэрэндашийн Цэрэн-Очирын нэрэмжит “АЙМГИЙН ЗАЛУУ ТАРИАЛАНЧ, МЕХАНИКЖУУЛАГЧ” шалгаруулах журам”-ыг хэрэгжүүлж эхэллээ.

Сумдаас улс, аймгийн аварга тариаланчаар шалгаран тодорхойлогдсон иргэн ААН-ийн материалыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн “Улсын аварга тариаланч хамт олон” 3, “Улсын аварга механикжуулагч иргэн” 4, “Улсын аварга тариаланч” 1, “Аймгийн аварга тариаланч хамт олон” 5, “Аймгийн аварга тариаланч, механикжуулагч” 9, “Хөдөлмөрийн баатар Цэрэндашийн Цэрэн-Очирын нэрэмжит Аймгийн залуу аварга тариаланч, механикжуулагч”-15 иргэнийг тус тус шалгарууллаа.

#### **5.4.Үйлдвэрлэл,үйлчилгээний хүрээнд:**

Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны VII хуралдааны 02 дугаар тогтоолоор 2022 оныг “Ногоон хөгжил-баялаг бүтээгчдийг дэмжих” урианы жил болгон зарлаж, урианы жилийн ажлыг зохион байгуулах хороо, салбар хороодыг байгууллаа.

Жижиг дунд, үйлдвэрлэл, үйлчилгээ, хоршооны салбарын өрсөлдөх чадварыг дээшлүүлж, эдийн засгийн хямралыг даван туулах үйлдвэрлэлийн өсөлтийг хангах, хөнгөлөлттэй зээл олгох, жижиг дунд үйлдвэр, хоршооны салбарын эдийн засаг, нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэх тэдний эрх ашигт нийцсэн бизнесийн таатай орчныг бүрдүүлэх зорилт дэвшүүлэн 24 хэрэгжүүлэх арга хэмжээ төлөвлөгөө боловсруулан ажиллаж эхэллээ. Хоршоог хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн, чанаргүй зээлтэй 18 сумын 56 иргэн, аж ахуй нэгжийн мэдээллийг хянан Монгол банкны хариуцагчийн зээлийн мэдээллийн сангийн хасуулах ажлыг зохион байгууллаа. Аймгийн үйлдвэр, худалдаа, үйлчилгээний хөдөлмөрийн аваргад нэр дэвшсэн 6 сумын 10 иргэний материалыг Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн “Худалдаа үйлчилгээний салбарын ажилтан”1, “Ахуйн үйлчилгээний салбарын ажилтан” 2, “Үйлдвэрлэгч-Баялаг бүтээгч” 2 тус тус шалгарлаа.

#### ***Зургаа. Стандарт, хэмжилзүйн чиглэлээр:***

**6.1.** Зуунмод, Баянцагаан сумын худалдаа, үйлчилгээ эрхлэгч 14 иргэн, аж ахуйн нэгжийн тохирлын гэрчилгээ шинээр авах буюу сунгуулах хүсэлтийн дагуу ажиллаж, хүнсний дэлгүүр 10, баар, цайны газар 2, дэн буудал 1 тус тус тохирлын гэрчилгээ хэрэглэх эрхийг 1-2 жилийн хугацаатай олгож, стандартын шаардлага хангалтгүй үнэлэгдсэн Зуунмод сумын 1 хүнсний дэлгүүрт үл тохирлын мэдэгдэл хүргүүлж ажиллалаа. Зуунмод сумын 15 худалдаа үйлчилгээ, нийтийн хоолны цэгийн 22 жинд шалгалт баталгаажуулалтыг хийлээ.

#### ***Долоо. Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:***


**7.1. Орчны бохирдолын талаар:** Аймгийн хэмжээнд нийтийн эзэмшлийн зам талбай, явган хүний замын цас мөсийг 107 байгууллага, 450 иргэдийн оролцоотойгоор нийт 120,4 м3 газрыг цэвэрлэлээ.

**7.2 Биологийн төрөл зүйлийн ажлын хүрээнд:** Зэрлэг ан амьтанд зориулан биотехникийн арга хэмжээ авах ажлыг Баянцогт, Баян-Өнжүүл, Баянчандмань, Эрдэнэсант сумдад зохион байгуулж сумын БХНСАХЗ-аас 2,3 сая төгрөг зарцуулан 3,5 тн хужир тавьсан.


**7.3. Аялал жуулчлалын хүрээнд:** Уул ус байгаль дэлхийдээ хүндэтгэл үзүүлж шинэ оны анхны нарнаас энерги авахын зэрэгцээ дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлэх, нийтийн биеийн тамирыг түгээн дэлгэрүүлэх зорилгоор 5 дахь жилдээ 01 дүгээр сарын 01-ний өдөр “Шинэ оны анхны нар харах” аялалыг зохион байгуулж 40-45 хүн хамрагдлаа.

**Найм. Ус, цаг уур, орчны шинжилгээний чиглэлээр:**

**Агаарын дундаж температур:** Нийт нутгаар  $-21.7^{\circ}\text{C}$ ... $-11.7^{\circ}\text{C}$  байснаас Алтанбулаг суманд  $-21.7^{\circ}\text{C}$ , Дэлгэрхаан суманд  $-11.7^{\circ}\text{C}$  байлаа. /Зураг-1/ **Олон жилийн дундажтай харьцуулахад:** Аргалант суманд  $0.9$  градус орчим, бусад сумдын нутгаар  $1.5^{\circ}$ ... $8.6^{\circ}\text{C}$ -ээр дулаан байлаа. /Зураг-2/



/Зураг-1/



/Зураг-2/

**Хөрсний дундаж температур:** Нийт нутгаар  $-23^{\circ}\text{C}$ ... $-14^{\circ}\text{C}$  байснаас Алтанбулаг суманд  $-23^{\circ}\text{C}$ , Заамар суманд  $-14^{\circ}\text{C}$  байлаа.

**Агаарт  $30^{\circ}\text{C}$ -ээс хүйтэн өдрийн тоо:** 1-12 өдөр байсны 12 өдөр нь Алтанбулаг суманд, 1 өдөр нь Зуунмод суманд, харин Эрдэнэсант, Заамар суманд  $30^{\circ}\text{C}$ -ээс хүйтэн өдөр ажиглагдаагүй. **Хөрсөнд  $40^{\circ}\text{C}$ -ээс хүйтэн өдрийн тоо:** Зуунмод суманд 1 өдөр, Алтанбулаг суманд 2 өдөр ажиглагдсан байна.


**Агаарын температурын үнэмлэхүй их утга:** нийт нутгаар  $-2.4^{\circ}\text{C}$ ... $+7.3^{\circ}\text{C}$  хүрснээс Дэлгэрхаан суманд 07-ны өдөр  $+7.3^{\circ}\text{C}$ , **хөрсний үнэмлэхүй их утга:**  $+1^{\circ}\text{C}$ ... $+12^{\circ}\text{C}$  ажиглагдсанаас Баян суманд 03-ны өдөр  $+12^{\circ}\text{C}$  хүрсэн байна.

**Агаарын үнэмлэхүй бага утга:** нийт нутгаар  $-39.3^{\circ}\text{C}$ ... $-27.8^{\circ}\text{C}$  байсан ба Алтанбулаг суманд 25-ны өдөр  $-39.3^{\circ}\text{C}$ , **хөрсөнд үнэмлэхүй бага утга:**  $-42^{\circ}\text{C}$ ... $-33^{\circ}\text{C}$  ажиглагдсанаас Алтанбулаг суманд 25-ны өдөр  $-42^{\circ}\text{C}$  хүрч хүйтэрсэн.


**Тунадасны хувьд:** Нийт нутгаар  $0.0$ - $2.4$  мм тунадас орсон, хамгийн их нь Баян-Өнжүүл суманд  $2.4$  мм, хамгийн бага нь Мөнгөнморьт, Заамар, Аргалант сумдад  $0.0$  мм орсон.

/Зураг-3/

**Олон жилийн дундажтай харьцуулахад:** Баян-Өнжүүл сумын нутгаар дунджийн орчим, бусад сумдын нутгаар дунджаас бага тунадас орсон./Зураг-4/



/Зураг-3/



/Зураг-4/

**Салхины дундаж хурд:** нийт нутгаар 0.0-3.4 м/с байснаас Борнуур суманд 0.0 м/с, Баянцагаан суманд 3.4 м/с байв. **Салхины их хурд:** 6-19 м/с хүрснээс хамгийн их нь Зуунмод суманд 02-ны өдөр 19 м/с хүрсэн байна. **10 м/с-ээс их хурдтай өдрийн тоо:** 1-8 өдөр байсны 8 өдөр нь Баянжаргалан, Дэлгэрхаан сумдад, Алтанбулаг, Баянчандмань, Бүрэн, Лүн, Заамар сумдад 1 өдөр ажиглагдсан. Баян-Өнжүүл, Жаргалант, Борнуур, Батсүмбэр, Цээл, Аргалант, Өндөрширээт сумдаар 10 м/с-ээс их хурдтай өдрийн тоо ажиглагдаагүй.

**15 м/с-ээс их хурдтай өдрийн тоо:** Зуунмод, Дэлгэрхаан сумдын нутгаар 1 өдөр, бусад сумдын нутгаар ажиглагдаагүй байна.

**Урьдчилан мэдээлэх:** Нарийвчилсан мэдээ, 1 хоногийн мэдээ, 5 ба 7 хоногийн мэдээ, сарын болон улирлын мэдээ, өнгөрсөн 1 болон 7, 10 хоног тутмын цаг агаарын тойм, энэ сарын 14, 22, 23-ны өдрүүдэд цас орж, зарим газраар цасан шуурга шуурч, салхи шуургатай байхыг анхааруулах мэдээг 3 удаа гаргаж, И-мэйл-ээр дамжуулж, [www.tuv.tsag-aagaar.gov.mn](http://www.tuv.tsag-aagaar.gov.mn) сайт, TuvTsagiug page-д байршуулан, өдөр тутмын цаг агаарын мэдээг Зуунмод сумын ОНИМ-ийн ажилтанд И-мэйл ба “Дотоод удирдлагын систем”-ээр явуулах ажил тасралтгүй хийгдэж, байгууллагын урсдаг гэрлэн самбарт нарийвчилсан, хоногийн мэдээг өдөр бүр байршуулан ард иргэдэд үйлчилж байна.

**Байгаль орчны шинжилгээний лаборатори:** Агаарын чанарын хүхэрлэг хий, азотын давхар ислийн сорьц авч шинжилгээг хийн агаарын чанарыг тодорхойлж байна. Агаарын чанарын ажиглалтыг 01 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар нийт 48 удаа ажиглалт хийсэн ба хүхэрлэг хийн дундаж агууламж 0.024 мг/м<sup>3</sup> азотын давхар ислийн дундаж агууламж 0.017 мг/м<sup>3</sup> үзүүлэлттэй байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад хүхэрлэг хий 0.002 мг/м<sup>3</sup>, азотын давхар ислийн 0.007 мг/м<sup>3</sup> дундаж агууламж нэмэгдсэн байна.

#### **Гадаргын усны чанар:**

Усны чанарын хяналт шинжилгээний хөтөлбөрийн дагуу 01 дүгээр сард Туул-Лүн голд хяналт шинжилгээг хийхэд цахилгаан дамжуулах чанар нь 365  $\mu$ S/cm гарлаа.

Төв аймгийн нутаг дэвсгэрт 7 ус судлалын харуул ажиллаж байгаагаас 2022 оны 01 дүгээр сарын 21-ний байдлаар усны түвшин:

Хэрлэн гол Хэрлэн-Хонгон харуулд 194 см, Хэрлэн-Мөнгөнморьт харуулд 122 см, Туул гол Туул-Алтанбулаг харуулд 572 см, Туул-Лүн харуулд 137 см, Туул-Заамар харуулд 163 см тус тус байсан ба өмнөх оны мөн үетэй харьцуулахад Хэрлэн гол Хэрлэн-Хонгон, Хэрлэн-Мөнгөнморьт харуулууд 6-19 см бага, Туул гол Туул-Алтанбулаг, Туул-Лүн, Туул-Заамар харуулууд 9-16 см их, Сөгнөгөр гол Сөгнөгөр-Сөгнөгөр харуул, Шивэрт гол Шивэрт-Борнуур харуулууд ёроолдож хөлдсөн.

Хэрлэн, Туул, Сөгнөгөр голууд нь 60-120 см-ийн зузаан мөсөн бүрхүүл үүссэн ба аж ахуйн нэгж байгууллага, ард иргэд мөсөн дээгүүр тээвэр хийхэд цөмрөх аюултай тул голын гарам, гарцаар гарч байхыг онцгойлон анхааруулах мэдээгээр үйлчилж байна.

#### **Тав. Нийгмийн бодлогын хэлтсийн хүрээнд:**

##### **Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар:**

##### **Хүүхдийн хөгжил, хамгааллын чиглэлээр:**

Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох нэмэлт өөрчлөлттэй холбогдуулан Угтаалцайдам, Сүмбэр сумдын 2 хүүхдийн “Хүүхдийн мөнгөн тэтгэмж”-ийг зогсоож, 12 хүүхдийн сэргээн олголтыг хэвийн болголоо. Хүүхдийн тусламжийн утас-108”-д 13 дуудлага мэдээллийг сумдын Хамтарсан багт шилжүүлэн хяналт тавьж, 7 дуудлага мэдээллийг хааж ажиллалаа. Хүүхэд хамгааллын чиглэлээр 5 эцэг эх, асран хамгаалагч, 6 сумын Нийгмийн бодлогын мэргэжилтнүүдэд утсаар зөвлөгөө өгсөн. Хүүхдийн эрхийн зөрчлийн 2 гомдол



мэдээлэл хүлээн авч, 1 гомдол мэдээллийг харьяалалын дагуу шилжүүлж, 1 гомдлыг Зөрчлийн хэрэг нээн ажиллаж байна.

**Гэр бүлийн хөгжил, хамгааллын чиглэлээр:**

Нийгмийн ажлын мэдээллийн сан нэвтрүүлж байгаатай холбогдуулан хамтарсан багийн 33 ахлагч, нарийн бичиг нарын судалгааг сумдаас шинэчлэн авч нэгтгэн, хамтарсан багийн 66 гишүүнд тус программд нэвтрэх эрх нээж, НАМС мэдээллийн сангийн хэрэглэгчид буюу хамтарсан багийн ахлагч, нарийн бичиг нарт зориулсан сургалтад 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдөр цахимаар хамруулсан.

Төв аймаг дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхийн шүүгчийн 2022 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 151/Ш32022/00246 дугаар захирамжаар Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтнийг шинжээчээр томилж, захирамжийн дагуу гэр бүлийн асуудал хариуцсан мэргэжилтнээр ахлуулсан шинжээчийн баг хүүхдийн асаргаа тогтоолгох маргаанд нөхцөл байдлын үнэлгээ хийхээр 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Зуунмод сумын 2 дугаар багт оршин суух хариуцагчийн талд ажиллалаа.

Осол гэмтлээс урьдчилан сэргийлэх сарын аяны хүрээнд Хүүхдийг осол гэмтэл, аливаа болзошгүй эрсдлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7 төрлийн постер мэдээллийг бэлтгэн олон нийтэд түгээсэн.

Аймгийн Цагдаагийн газартай хамтран зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр “Хүүхдийн хүмүүжилд аавуудын үүрэг, оролцоо” сэдвээр Цагдаагийн газрын түр саатуулах байранд гэр бүлийн хүчирхийлэл, замын хөдөлгөөний зөрчлөөр 7-30 хоногоор баривчлагдсан 15 хүмүүжигчид зохион байгуулж, согтууруулах ундааны хэрэглээний түвшин тогтоох сорил авч, 3 иргэнд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажиллалаа.

**Залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр:**

Ковидын өвчлөл ихссэнтэй холбоотойгоор “Ковидын эсрэг хамтдаа халдвар хамгааллын дэглэмээ сахицгаая!” цуврал постерийг байгууллагын пэйж хуудсанд байршуулж, 744 хандалт авсан байна.

2021 оны онцлох ажлыг нийтэд хүргэх зорилгоор “ОНЦЛОХ АЖИЛ-2021” постер бэлтгэн пэйж хуудас болон байгууллагын цахим хуудсанд байршуулан олон нийтэд сурталчилж, хандалтын тоо 225, 10 шэйр хийсэн байна.

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн дэлгэрэнгүй судалгааг 27 сумаас авч нэгтгэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын дэргэдэх Залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн. Мэргэжлийн чиг баримжаа олгох, Гэр бүлийн харилцааны асуудлаар 17-29 насны 3 иргэнд сэтгэлзүйн зөвлөгөө үйлчилгээ үзүүлж ажиллалаа.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг ГБХЗХГ-ын дэргэдэх Залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулсан “Өөрөөсөө зугтаж өөрийгөө бүтээ” цахим сургалтад Залуучуудын хөгжлийн төвийн 3 ажилтан хамрагдлаа.

**Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар:**

**Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээ**

2022 оны 01 дүгээр сарын байдлаар 1749 иргэнд 332.1 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэвэр, 1156 иргэнд 102.1 сая төгрөгийн нийгмийн халамжийн тэтгэмж, 250 иргэнд 42,8 сая төгрөгийн амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмж, 3 иргэнд 3,6 сая төгрөгийн онцгой тохиолдолын мөнгөн тэтгэмж, 9337 эхэд 1212,7 сая төгрөгийн “Алдарт эх” 1, 2-р зэргийн одонтой эхийн мөнгөн тэтгэмж, 5578 ахмад настанд 451,3 сая төгрөгийн насны хишиг тэтгэмж, 83 ахмад настанд 11,1 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, 72 хөгжлийн бэрхшээлтэй иргэнд 8,1 сая төгрөгийн хөнгөлөлт тусламж, хүнс тэжээлийн тусламж шаардлагатай 5438 иргэнд 64,7 сая төгрөг, жирэмсэн 494 эхэд 18,8 сая төгрөгийн



тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарсан 4049 эхэд 200,3 сая төгрөгийн тэтгэмж, Өрх толгойлсон 3 эх /эцэг/-т 0,9 сая төгрөг, ихэр хүүхэд төрүүлсэн 4 ихэр хүүхдэд 8,0 сая төгрөг, 33376 хүүхдэд 3337,6 сая төгрөг нийт давхардсан тоогоох 61592 иргэнд 5793,8 сая төгрөгийг тус тус олгосон.

**Нийгмийн хөгжлийн чиглэлээр**

Төрийн аудитын газарт Холт ОУБ-ын дэмжлэгээр хамтран хэрэгжүүлдэг “Хүүхдийн амьжиргааг дэмжих төсөл”-ийн 2021 оны тайланг хүргүүлж төсөлд хамрагддаг хүүхдүүдийн эцэг эхийн банкны дансны мэдээллийг шинэчилж 01 дүгээр сард олгогдох санхүүжилтийг гаргасан. 2022 онд шинээр “Алдарт эх”-ийн 1, 2 дугаар одонгийн болзол хангаж, шагнагдах эхчүүдийн материал ирүүлэх албан тоотыг сумдын Засаг дарга, сумын хөдөлмөр эрхлэлт, нийгмийн халамжийн асуудал хариуцсан мэргэжилнүүдэд хүргүүлж, одонгийн материал бүрдүүлэх журмын талаар заавар чиглэл өгч материал хүлээн авч эхэлсэн.

**Өрхийн мэдээллийн нэгдсэн сан, хүнс тэжээл, хүүхдийн мөнгөний талаар:**

Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээг 975 өрхийн 2661 иргэн 2777 хүүхдэд 64,792.0 мянган төгрөгийн 10 төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг олгож, хүнс тэжээлийн дутагдлаас урьдчилан сэргийлж дэмжлэг үзүүлсэн. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд хамрагддаг хөдөлмөрийн насны боловч хөдөлмөр эрхлээгүй 905 иргэний тоон судалгааг гаргаж нэгтгэсэн. Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээнд шинээр 1 өрхийн 1 том хүн, 5 хүүхдийг хамруулсан. Өрхийн амьжиргааны түвшинг тодорхойлох судалгааны мэдээлэл зөрүүтэй өгсөн 12 өрхийн мэдээллийг мэдээллийн сангуудтай тулган баталгаажуулж оноог бодуулахаар уламжилж төлбөрийн чадваргүй 2 иргэнд амьжиргааны түвшний тодорхойлолтыг албан тоотоор гаргаж хүргүүлсэн.

И-халамж системд шинэ төрсөн хүүхдийн мөнгө авах хүсэлт гаргасан 169 хүүхдийн бүртгэлийг баталгаажуулсан. Хүүхдийн мөнгөн тэтгэмжийн журам шинэчлэгдсэнтэй холбогдуулан сумдад цахимаар мэдээлэл өгч арга зүйгээр хангаж хүүхдийн мөнгөн тэтгэмжийг бэлнээр авах хүсэлийг аймгийн хэмжээнд зохион байгуулан ажилласан. Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 33376 хүүхдэд 3,337.6 сая төгрөг олгосон.

**Хөдөлмөр эрхлэлтийн чиглэлээр:**

**Хөдөлмөрийн зах зээлийн мэдээллийн нэгдсэн сан:**

Тайлант хугацаанд 126 иргэний 24342,1 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн эргэн төлөлт ХЭДСанд төвлөрсөн байна.

**Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээний хүрээнд:**

Шинэ нисэх онгоцны буудлын нийтийн хоолны үйлчилгээг үзүүлэх тендерт шалгарсан Эв Эе ХХК-аас тогооч, бэлтгэгч, касс гэх мэт 14 ажлын байрны захилга ирүүлсний дагуу Зуунмод сумын идэвхитэй ажил хайгчаар бүртгэлтэй 32 иргэдийг халдвар хамгааллын дэглэм баримтлан 2022.01.26-27-ны өдрүүдэд ажил олгогчтой ажлын ярилцлага хийсэн. 02 дугаар сард ажлын байрны танилцуулга хийсний дараа ажилчдаа сонгон шалгаруулж авахаар шийдвэрлэсэн.

Ус цаг уурын газар, Төв АЗЗА ХХК, Нийтийн номын сан, Цэцүүх трейд ХХК-с ирсэн ажлын байрны захиалгын дагуу 7 ажил хайгч иргэнд зуучлалын хуудас бичиж өгч 1 иргэн ажилд зуучлагдсан.

**Нийгмийн даатгалын хэлтэс:**

**Хяналт шалгалтын чиглэлээр:**

“Нийгмийн даатгалын тухай хууль”-д заасан болзол хангаж шинээр тэтгэвэр тогтоолгосон 101 тэтгэврийн хувийн хэргийг түүвэрлэн шалгаснаас 24 хувийн хэрэгт бүрдүүлсэн баримт бичгийн бүрдэл дутуу, шаардлага хангаагүй зөрчил илэрснийг

арилгуулахаар байцаагчид, хувийн хэрэг бүрдүүлэн баримт бичиг шаардлага хангасан 77 тэтгэврийг хянаж тэтгэвэр авах эрхийн нөхцлийг хангаж ажиллалаа.

Тэтгэвэр олголтыг цахимаар хянах ажлын хүрээнд тэтгэвэр авагчдын тэтгэвэр олголтыг шалгаж 3 тэтгэвэр авагчийн хөдөлгөөн Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллээс зөрүүтэй хийгдсэн зөрчлийг илрүүлж, илэрсэн зөрчлийг байцаагч нараар арилгуулж зөвлөмж, үүрэг өгч ажиллалаа.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг нийгмийн даатгалын ерөнхий газрын албан бичгийн хүрээнд хэлтсийн даргын баталсан удирдамжийн дагуу Төв аймгийн хэмжээнд 537 даатгуулагчийн чөлөөлөлт дутуу хийгдсэн тооцоог шалгаж мэдээллийн санд залруулга хийлгэхээр СБТасагт жагсаалтаар шилжүүлж ажилласан.

**Нийгмийн даатгалын сангийн чиглэлээр:**

2021 оны 01 дүгээр сард аж ахуйн нэгж байгууллагуудын шимтгэлийн орлогоор 3,4 тэрбум төгрөг, 4605 сайн дурын даатгуулагчдаас 260,8 сая төгрөгийн орлого төвлөрүүлсэн бөгөөд үүнд 3320 малчин, 1285 хувиараа хөдөлмөр эрхлэгч, ажил хөдөлмөр эрхлээгүй болон оюутан, бусад даатгуулагч иргэд байна. Эрүүл мэндийн даатгалд 715 малчин, ажил хөдөлмөр эрхлээгүй 406, нийт 1121 даатгуулагчийн 84,5 сая төгрөгийг эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн. Жирэмсэн амаржсаны тэтгэмж 66 даатгуулагчид 928,4 сая, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж 90 даатгуулагчид 13,4 сая, ажилгүйдлийн тэтгэмж 187 даатгуулагчид 89,08 сая төгрөг тус тус олгосон байна. Хаан банк, Төрийн банкаар дамжуулан 17260 тэтгэвэр авагчдад 6134,13 сая төгрөгийн тэтгэврийг аймгийн хэмжээнд олгон ажилласан.

**Дотоод үйл ажиллагааны чиглэлээр:**

Аймгийн хэмжээнд архивын лавлагаа 50, тодорхойлолт 20, нийт 70 лавлагаа, тодорхойлолт гарган иргэн даатгуулагчдад өгч ажиллалаа.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын хамтарсан тушаалыг үндэслэн хөдөлмөрийн чадвар түр алдсаны болон жирэмсний амаржсаны эмнэлгийн хуудсыг “E-Health” систем ашигладаг 2, 3-р шатлалын эмнэлгүүд, Улаанбаатар хотын өрхийн эмнэлгүүд 01 дүгээр сарын 17-ны өдрөөс эхлэн цахимаар олгож байгаатай холбогдуулан 3 удаагийн сургалтад хамрагдаж ААН байгууллагууд чиглэл өгч ажиллалаа.

**Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын чиглэлээр:**

Нийгмийн даатгалын хэлтсийн дэргэдэх ЭХМК-ын хурлыг 3 удаа 25 цаг хуралдаж, нийт 204 иргэний асуудлыг хэлэлцсэнээс шинээр 36 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацааг тогтоож, 150 иргэний хөдөлмөрийн чадвар алдалтыг сунгаж, 16 иргэнийг цуцалсан байна.

**Биеийн тамир спортын газар:**

Шинэ үндсэн хууль батлагдсаны 30 жилийн ойн хүрээнд Аймгийн ЗДТГ-ын ХЭЗХ-тэй хамтран Хөдөлмөрийн хуулийн талаар сургалт авч, АХА, үндэсний өв шагайн наадгай, шагай харвах тэмцээн зохион байгуулж, албан хаагчдыг бүрэн хамрууллаа.

Өвөрхангай аймагт 2022.01.21-23-нд Дэлхийн Таеквондогийн KUKKIWON-ны Монгол дахь албан ёсны суурин төлөөлөгч, шигшээ багийн дасгалжуулагч, хар бүс 7 дантай Хо Инён Монголын Таеквондо холбооны багш дасгалжуулагч нарт зориулсан сургалт, шалгалтын арга хэмжээ зохион байгуулагдаж Төв аймгийн 4 тамирчин хар бүс 1 даныхаа шалгалтыг амжилттай өглөө.

“ОЛИМПИЗМ-СПОРТ-БИЕ БЯЛДРЫН ХҮМҮҮЖИЛ” болзолт уралдааныг Төв аймагт зохион явуулах цахим уулзалтыг 2022.01.19-нд Боловсрол, шинжлэх ухааны газар, Биеийн тамир спортын газар, Олимпийн зөвлөлтэй хамтран 27 сумын ЕБС-ийн захирал, биеийн тамирын багш нарт хийж 42 хүн хамрагдлаа.

Сонин шийдэл кредит ББСБ-ын нэрэмжит 2022 оны өсвөрийн цаначдын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022.01.08-нд Зуунмод суманд зохион байгуулж Алтанбулаг, Борнуур, Заамар, Жаргалант, Цасан зам клуб, Хэнтий аймаг гэсэн 6 байгууллагын 41 тамирчин 10 хүртлэх нас, 11-12, 13-14, 15-16 насны ангилалд хурд хүчээ сорин өрсөлдлөө.

Баянцагаан сумын залуучуудын дундах сагсан бөмбөгийн тэмцээн 2022.01.08-нд зохион байгуулагдаж 17 багийн 106 тамирчин оролцсон.

“Үндсэн хууль” батлагдсаны 30 жилийн ойг тохиолдуулан Аймгийн ЗДТГ-ын хэлтсүүдийн дундах 3 төрөлтийн тэмцээн 2022.01.09-нд зохион байгуулагдан 8 багийн нийт 128 тамирчин өрсөлдлөө.

2022 онд үндэсний спортын VII наадам зохион байгуулахтай холбогдуулан 02 дугаар сард зохион байгуулагдах улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдыг сонгон шалгаруулах зорилгоор мөсний сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2022.01.15-16-ны өдрүүдэд нийсэхийн мөсөн талбайд зохион байгуулж 19 сумын 3 багийн 31 тамирчин оролцож цэц мэргэнээ сорин өрсөлдсөнөөс МУ-ын гавъяат багш Д.Ичинхорлоогийн нэрэмжит Төвийн бүсийн гүйлтийн цанын аварга шалгаруулах тэмцээн 2022.01.24-26-ны өдрүүдэд Төв аймгийн Борнуур суманд зохион байгуулагдаж Сэлэнгэ, Архангай, Өвөрхангай, Дархан, Булган, Орхон, Хэнтий, Төв, Улаанбаатар хотоос нийт 11 клубын 70 гаруй тамирчид оролцлоо.

2022 оны өсвөр үеийн гүйлтийн тэшүүрийн аймгийн аварга болон улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох тамирчдын сорилго тэмцээнийг 2022.01-26-нд Төв аймгийн Эрдэнэ суманд зохион байгуулж 2 сумын 3 багийн 32 тамирчид оролцлоо. “Багануур-Classic” хүчний 3 төрөлт тэмцээн 2022.01.22-23-нд Багануур хотноо зохион байгуулагдаж Төв аймгийн баг тамирчид 2 алт, 5 мөнгө, 5 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр 3-р байрыг эзэллээ. Монголын Пара цанын бааз байгуулагдсаны 12 жилийн ой, цана дугуйн холбооны нэрэмжит өсвөрийн цаначдын аварга шалгаруулах нээлттэй тэмцээн 2022.01.22-нд Гавьжийн шандад зохион байгуулагдаж Архангай, Дархан, Төв, Цаначин клубын нийт 50 гаруй тамирчид оролцож, манай баг тамирчид 7 алт, 5 мөнгө, 3 хүрэл медаль хүртэж багийн дүнгээр тэргүүн байр эзэллээ.

Кураш бөх болон бүстэй барилдааны Улсын аварга шалгаруулах өсвөр үеийн тэмцээнд манай тамирчид 1 алт, 3 мөнгөн медаль хүртлээ.

“Жюү жицүгийн 2022” оны Улсын өсвөр үеийн аварга шалгаруулах тэмцээнд 2022 оны 1-р сарын 14-16-нд спортын төв ордонд болж 1068 бөх оролцлоо. Тус тэмцээнээс манай тамирчид 6 алт, 4 мөнгө, 4 хүрэл медаль хүртлээ

2022 оны 13 дахь удаагийн пауэрлифтингийн "Хэвтээ шахалтын" Улсын аварга шалгаруулах тэмцээн 2022.01.15-16 нд болж манай тамирчид 4 мөнгө, 4 хүрэл медаль хүртэж, багаараа 3-р байранд шалгарлаа.

“Цомын” аварга шалгаруулах тэшүүрийн нээлттэй тэмцээн 2022.01.15-16-нд Хандгайтын мөсөн талбайд болж, 9 байгууллагын 60 гаруй тамирчид оролцсоноос 3 алт, 6 мөнгө, 5 хүрэл медаль хүртэж, багийн дүнгээр Төв аймаг 2-р байр эзэллээ.

### **Боловсрол, шинжлэх ухааны газар:**

Ерөнхий боловсролын 30 сургуулийн нэгдүгээр улиралд сурлагын хоцрогдол нөхөх арилгах үйл ажиллагааны тайланг 7 бүсээр хэлэлцэн туршлага судалсан бөгөөд бүсийн тайлангаа нэгтгэн аймгийн нэгдсэн хэлэлцүүлэг зохион байгууллаа. Хэлэлцүүлэгт ЕБС-ийн 29 захирал, БСУГ-ын 7 мэргэжилтэн оролцсон.

Багш бүр сургуульдаа нэгдүгээр улирлын “Сурлагын болон агуулгын хоцрогдол нөхөхөд хүрсэн үр дүн, туршлага”-ын тайлангаа тавьж, дараа нь аймагт 9 мэргэжлийн

бүлгээр нэгдсэн танилцуулга бэлтгэж хэлэлцүүлсэн. Хэлэлцүүлэгт 48 сургалтын менежер, суурь, бүрэн дунд боловсролын 461 багш оролцсон.

Гадаад хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх жил болгон зарласантай холбогдуулан сурагчдын улирлын амралтыг тохиолдуулан 8 багш, 151 суралцагчдыг хамруулан 6,7 дугаар ангийн сурагчдын дунд Дуу шүлэг, өгүүллэгийн, 8,9 дүгээр ангийн сурагчдын дунд Зохион бичлэгийн, 10-12 дугаар ангийн сурагчдын дунд Илтгэлийн, Гадаад хэлний багш нарын дунд Илтгэлийн зэрэг 4 төрлийн цахим уралдаан зохион байгууллаа.

"Хүмүүжлийн эерэг арга" орон нутгийн сургагч багш бэлтгэх цахим сургалтыг 6 хэсэгт бүсчлэн зохион байгуулж, нийт 19 удирдах ажилтан, 542 багш, 23 ажилтан албан хаагчдыг хамруулсан. Сурагчдын сурлагын хоцрогдол нөхөх, арилгах үйл ажиллагааны 1-р улирлын явцын тайланг хэлэлцүүлж, нийт 30 сургуулийн Нийт 29 тайланг хэлэлцүүлээ.

Багш нарын интерактив хичээл бэлтгэх, холимог сургалтын арга зүйгээр цахим хичээл зохион байгуулах чадварыг дээшлүүлсэн. Сургалтад 31 сургуулийн бага боловсролын менежер, 312 багш нийт 343 хүн оролцлоо.

Багш нарын цахим хичээл бэлтгэх чадвар сайжруулах **"Сурах арга барилыг дэмжсэн ажлын хуудас боловсруулах арга"** сэдэвт сургалтад 31 сургуулийн бага боловсролын менежер, 299 багш нийт 331 хүн хамрагдсан.

### **Албан бус насан туршийн боловсрол төв:**

Насан туршийн боловсролын төв болон нэгжийн багш нарт Насан туршийн боловсролын үндэсний төвөөс 01 дүгээр сарын 4-5 хооронд "Тогтвортой хөгжлийн боловсрол, Тэгш хамруулах боловсрол ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжил" 2 өдрийн цахим сургалт зохион байгууллаа.

### **Эрүүл мэндийн салбарын хүрээнд:**

Аймгийн хэмжээнд 2021 оны 12 дугаар сарын байдлаар 1130 эх төрж өнгөрсөн мөн үеийнхээс 58 тохиолдлоор өссөн ба 1129 нярай бүртгэгдсэн байна. Жирэмсний хяналтад 702 эмэгтэй байна. Нийт 1413 жирэмсэнг хяналтад авснаас эхний 3 сартайд хяналтад 91.08% хамрагдсан. Нийт 289641 үзлэг хийсэн бөгөөд үүнээс урьдчилан сэргийлэх үзлэг 140250, амбулаторийн үзлэг 112 151, идэвхитэй хяналтын 24219 үзлэг хийж гүйцэтгэсэн байна. Түргэн тусламжийн дуудлагаар 16402 хүнд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлсэн ба үүнээс алсын дуудлага 24.69%, осол гэмтлийн дуудлага 1.92%-ийг эзэлж байна. Стационарт 19405 хүн эмчлэгдэн нийт 154531 ор хоног ашигласан байна. Дундаж ор хоног 8.0 байна.

2022 оны 01 дүгээр сард Коронавируст халдвар (Ковид-19)-ын нийт 3692 батлагдсан тохиолдол бүртгэгдэж хариу арга хэмжээг зорилтод бүлгээр ялган тандалт хийж бүртгэн, гэрийн тусгаарлалтын мэдээг тухай бүр гарган ажилласан.

01 дүгээр сард 16 аж ахуйн нэгж байгууллагын нийт 9697 мк талбайд эцсийн халдваргүйтгэл хийсэн.

Коронавируст халдварын эсрэг дархлаажуулалтад 01 сарын 30-ний байдлаар аймгийн хэмжээнд 1-р тунд 60030, 2-р тунд 57667, 3-р тунд 26361, 4-р тунд 1154 хүн хамрагдсан.

2022 оны 01 дүгээр сард Аймгийн хэмжээнд COVID-19-ын антиген илрүүлэх түргэвчилсэн шинжилгээг нийт 4843 иргэнээс авч 2434 сөрөг, 2409 эерэг гарсан. ПГУ шинжилгээний 3333 сорьц авсанаас 1283 эерэг, 2050 сөрөг гарсан.

Коронавируст халдвар (ковид-19)-тай 3820 иргэнийг эмнэлгийн тусламж үйлчилгээнд хамруулснаас, 2485 иргэнийг эмчилж, нас барсан-2, одоогоор 1333 иргэнийг эмчилгээнд хамруулж байна.

Сумын ЭМТөвд ажиллаж буй эх баригч нарыг чадавхжуулах, анхан шатны тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгоор Эрүүл мэндийн газрын даргын баталсан удирдамж, хөтөлбөрийн дагуу Цээл сумын Эрүүл мэндийн төвийн 1 эх баригчийг Аймгийн нэгдсэн эмнэлгийн Төрөх тасагт 5 хоног сэлгэн ажиллуулж дадлагажуулсан.

Төв аймагт “Хиймэл шүдний үйлдвэрлэл” явуулдаг байгууллагын үйл ажиллагаанд ХШҮ хийж 2022 онд магадлан итгэмжлэлд хамрагдах 18 эрүүл мэндийн байгууллагуудын бүрдүүлэх материалыг хянан, зөвлөн туслаж, цахим програмд ерөнхий мэдээллийг бүрэн оруулсан.

Аргалант сумын Эрүүл мэндийн төвийн Ковид-19 халдварын хариу арга хэмжээ, тандалт хийх арга хэмжээнд зөвлөн туслав. Төр, хувийн хэвшлийн 58 эмийн сангийн 2021 оны жор, борлуулалтын орлого, нөөцийн тайланг H-INFO STATA программд шивж, хяналт тавьж төр хувийн хэвшлийн 45 байгууллагын эмнэлгийн тоног төхөөрөмжийн тайлан, 58 эмийн сангийн оны жор, борлуулалтын орлого, нөөцийн тайлан, 85 эрүүл мэндийн байгууллагын үндсэн үйл ажиллагаа, хүний нөөц хүчин чадлын тайланг H-INFO STATA программд шивж, хянан, Эрүүл мэндийн хөгжлийн төвд хүргүүлсэн.

Хүний нөөцийн шинэчилсэн програмд байгууллагын 46 албан хаагчдын мэдээллийг шинэчлэн оруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан Аз жаргалтай төв ажиллуулах төсөл боловсруулан, НБХ-т танилцуулан Дэлхийн Зөн ОУБ-т хүсэлт илгээсэн.

Орчны эрүүл мэндийн лабораторит Төв чандмань дулааны эрчим хүчний газрын 18 унд ахуйн усны шинжилгээ ирж 288 үзүүлэлтээр химийн шинжилгээ хийсэн.

Монголын Гэр бүлийн сайн сайхны нийгэмлэг ТББ-аас хэрэгжүүлж буй төслийн хүрээнд нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлтийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх, чанарыг сайжруулах зорилгоор жирэмслэхээс хамгаалах эм хэрэгслийг Нэгдсэн эмнэлэгт хүлээлгэн өглөө.

Монгол Улсын хүний гавьяат эмч Б.Алтангэрэл эмчийн гэр бүлийн зүгээс АНЭ-т Гемодиализын хэсэг болон Дотрын тасагт Тэргэнцэр 2 ширхэг ор хөнжлийн даавуу дэр, дуслын штатив зэргийг гардууллаа.

#### **Сургалт, сурталчилгаа:**

Тандалт, хариу арга хэмжээ авах тухай ЭМС-ын шинэчлэгдсэн тушаалаар Зуунмод сумын 6 багийн 18 ажилтанд сургалт хийж чадавхжуулсан. Мөн Зуунмод суманд үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагуудад ковид-19 цар тахлын зөвлөмж бэлтгэн тараасан. Эрүүл мэндийн хөгжлийн төвөөс зохион байгуулсан цахим магадлан итгэмжлэлийн 2 удаагийн сургалтад ЭМГ-ын 6 мэргэжилтэн хамрагдсан.

2022 оны 01 дүгээр сард магадлан итгэмжлэлд хамрагдах нийт 18 өрх, сумын Эрүүл мэндийн төвүүдийг цахим магадлан итгэмжлэлд хамрагдах болон цахим материал бүрдүүлэх аргачлалд сургах 2 удаагийн цахим сургалт зохион байгуулж, нийт 70 эмч, эмнэлгийн мэргэжилтэн оролцсон. Улсын Онцгой комисс, Нэгдсэн шуурхай штабаас зохион байгуулсан 3 удаагийн цахим сургалтад холбогдох алба хаагчид хамрагдсан.

Аймгийн Нэгдсэн эмнэлгийн хүүхдийн зөвлөх эмчтэй хамтран “Хүүхдийн эрэмбэлэн ангилалт, яаралтай тусламж”, “Хүүхдийн сэхээн амьдруулалт” сэдэвт онол, дадлага хосолсон 1 өдрийн ажлын байрны сургалтыг Цээл сумын Эрүүл мэндийн төвд зохион байгуулж, 11 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг хамруулан чадавхжуулсан

“Эерэг хандлагыг бүтээе сургалт”-ыг Олон улсын хүүхдийн “Найрамдал” цогцолборт зохион байгуулж, ЭМГ-ын албан хаагчид болон АНЭ-ийн эмч, эмнэлгийн ажилчдыг хамрууллаа. Сургалтаар “Хувь хүний хөгжил-Эерэг хандлага, харилцааны ур чадвар”, “Стресс менежмент”, “Гэр бүлийн хөгжил, харилцаа, хандлага”, “Аз жаргалын 5 хором” зэрэг сэдвүүдээр мэдээлэл хийсэн. Нийт 180 эмч, эмнэлгийн ажилтан хамрагдлаа.

“Коронавируст халдвар (COVID-19)-аас урьдчилан сэргийлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслээр халдвараас сэргийлэх сурталчилгааг насны онцлогт тохируулан ДЭМБ, НЭМҮТөв, ЭМЯ-аас өгч байгаа мэдээллийг телевизээр нийт 15 удаа, аймгийн зар

мэдээлэлийн 14 групп цахим сүлжээгээр 28 төрлийн постер 10 төрлийн зөвлөмж , 1500 сурталчилгаа, 8 төрлийн шторк, мэдээлэл байршуулсан. Нийт хандалтын тоо 97000.

Нэгдсэн эмнэлгийн мэс заслын тасгаас санаачилан Монголын гэр бүл сайн сайхны нийгэмлэгийн Төв аймаг дахь салбар, байгууллагын ёс зүйн хэсгийн хороотой хамтран "Урлагаар сэтгэл засахуй" Art therapy сургалтыг амжилттай зохион байгуулан, 20 эмч, эмнэлгийн ажилтныг хамрууллаа.

### **Эрүүл мэндийн даатгалын чиглэлээр:**

2021 онд 78 эрүүл мэндийн байгууллагад олгосон санхүүжилтийн мэдээг байгууллагуудтай тооцоо нийлж, санхүүгийн тайланг гарган ЭМДЕГ-т илгээлээ.

45 эмийн сан болон 1 өрхийн ЭМТ, 26 сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны "Тусламж, үйлчилгээ худалдан авах гэрээ"-ний хэрэгжилтийг удирдамж, журмын дагуу үнэлж дүгнэн нэгтгэл тайланг ЭМДЕГ-т илгээлээ. Аргалант, Баянцагаан сумын ЭМТөв, Заамар сумын Хан Жаргалант ирээдүй ХХК-ны "Билгүүн" эмийн сангууд хангалтгүй үнэлгээ авч хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

Аймгийн төрийн аудитын газраас "ЭМД-ын сангийн хөнгөлөлт, чөлөөлөлтийн үр дүн" сэдэвт гүйцэтгэлийн аудитын шалгалт явуулсан.

ЭМС-ын 2022 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/33 дугаар тушаалаар Коронавируст халдвар (Ковид-19)-ын оношлогоо, эмчилгээний түр зааврыг шинэчлэн баталсан ба тушаалыг судлан, аймгийн Эрүүл мэндийн байгууллагуудын эмч мэргэжилтнүүдэд танилцуулсан. Биеэр үйлчлүүлсэн 110, утсаар 25 иргэнд шимтгэлийн лавлагаа мэдээлэл өгч, 43 иргэний хүсэлтийн дагуу төр хариуцахын нөхөн ноогдуулалтыг хийсэн.

### **Соёл урлагийн газар:**

Соёл, Урлагийн газар шинээр үүсэн байгуулагдаж, 2022 оны 01 дүгээр сарын 03-ны өдрөөс эхлэн байгуулагдлаа.

Монгол Улсын Сангийн яамнаас байгууллагын үйл ажиллагааг хэвийн явуулахад нэн шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах 15.0 сая төгрөгийн дэмжлэг үзүүллээ. Энэхүү ажлын хүрээнд худалдан авах гэрээг "БИТЛИНК" ХХК-тай байгууллаа. Уг гэрээний дагуу суурин компьютер 5, монитор 4, гурван үйлдэлт принтер 1 ширхэгийг тус тус хүлээн авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Соёлын яамны Хөрөнгө оруулалтын хэлтэстэй хамтран аймгийн нийт 30 соёл, урлагийн байгууллагуудын хүний нөөц, цалингийн судалгаа, мөн сумдын соёлын төвүүдийн материалаг баазын хангалтын судалгааг нэгтгэн гаргаж хугацаанд нь хүргүүллээ.

Төв аймгаас СУИС-ийн Бүжгийн урлагийн сургуультай жил бүр хамтран зохион байгуулагддаг сумдын соёлын төвийн бүжгийн багш нарын мэргэшүүлэх сертификаттай сургалт 2022.01.24-28 ны өдрүүдэд Улаанбаатар хотод зохион байгуулагдаж нийт 14 бүжгийн багш хамрагдлаа. Энэхүү ажлын хүрээнд СУИС-ийн Бүжгийн урлагийн сургуулийн захирал, Соёлын урлагийн газрын дарга, Соёлын төвийн дарга нартай хамтран ажиллах гэрээ байгууллаа.

Соёл, урлагийн салбарын ТҮ1-3 нийтлэг үйлчилгээний 54 албан хаагчдын цалин орон нутгийн төсөвт тусгагдаж ирээгүй тул асуудлыг орон нутгийн төсвөөс шийдвэрлүүллээ. Статистикийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, Соёлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын 25 дугаар зүйлийн 25.1.5-д заасны дагуу аймаг, сумдын соёл, урлагийн байгууллагын 2021 оны статистик мэдээллийг нэгтгэж Соёлын яаманд явууллаа.

### **Нийтийн номын сангийн хүрээнд:**

Аймгийн Нийтийн номын сан нь 2021 оны 01 дүгээр сарын байдлаар танхимаар **280** байнгын уншигч, **632** ирэгсэд, нийт **912** уншигчдад **1557** ном олгож уншуулан үйлчиллээ.

“Гэрээр ном олгох танхим” нь **86** уншигчдад **253** ном гэрээр олгож уншуулсан байна. Зөөврийн номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлэх, хөдөө орон нутгийн алслагдсан багийн иргэдэд үйлчлэх тоо, чанарыг ахиулахын тулд Мөнгөнморьт сумын соёлын төвийн номын санчтай хамтран 30 номыг 2 сарын хугацаатайгаар “Зөөврийн номын сан”-ийн үйлчилгээг хүргэж, нэгдүгээр сарын байдлаар нийт 21 иргэнд 52 номоор үйлчиллээ. Нийтийн номын сангийн “Цахим мэдээллийн танхим”-аас цахим сан хөмрөгт байгаа сурагчдын заавал унших номоо Номын сангийн Facebook page хуудсанд цувралаар толилуулж байна. 7 ширхэг цахим номыг байршуулж **780** уншигчдын хүртээл болсон.

“Монгол Улсын үндсэн хуулийн өдөр”-ийг тохиолдуулан номын сангийн Facebook хуудсанд Үндсэн хуулиа баталж, улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлсэн мэдээ мэдээллийг байршуулж 318 хүний хандалт авсан байна. Мөн “Насанд хүрэгчдийн уншлагийн танхим”-д нээлттэйгээр “Үндсэн хууль-Тусгаар тогтнол” сэдэвчилсэн номын үзэсгэлэнг 25 номоор гаргаж 120 уншигчдын хүртээл болголоо.

Аймгийн нийтийн номын сангийн 2021 онд хэрэгжүүлсэн онцлох ажлуудыг иргэдэд сурталчлах зорилгоор ИНФОГРАФИК гаргаж байгууллагын цахим хуудас <http://library.to.gov.mn> сайт, Facebook page хуудсанд байрлуулан мэдээллийг **516** иргэдэд хүргэсэн байна. Нийтийн номын сангийн Гэрээр ном олгох танхимын сан хөмрөгийн төрөл анги болон уран зохиолын номын тооллого хийж нийт 12552 ном тоолсноос гадаад ном 710, монгол ном 11842 ширхэг байна. Үүнээс шаардлага хангахгүй 24 номыг актанд оруулахаар санал өгсөн.

Ковидын өвчлөл ихэссэнтэй холбогдуулан ЭМГазарт хүсэлт тавьж Номын сангийн өрөө, танхимуудад ариутгал хийлгэсэн.

### **Музейн үйл ажиллагааны хүрээнд:**

Америкийн Монгол судлалын төв болон Олон улсын Музейн холбооноос зохион байгуулж буй Музей болон “Соёлын өв, цуврал хэлэлцүүлэг онлайн вебинарт музейн мэргэжлийн 3 ажиллагсад оролцож мэдлэг боловсролоо дээшлүүллээ.

Шинэчлэгдсэн Төрийн албаны “Хүний нөөцийн удирдлагын мэдээллийн тогтолцоо” цахим системд 01 дүгээр сарын 10-21-ний өдрүүдэд ажиллагсдын мэдээллийг өгсөн зөвлөмжийн дагуу шинэчилж бүрэн оруулж, хувийн хэргийн мэдээллийг шинэчиллээ.

Музейн мэргэжил арга зүйн зөвлөлөөс “Миний нутгийн түүх” сэдэвтэй боловсролын ажлын төслийг бичиж Зуунмод сумын ЗДТГазартай хамтарч ажиллахаар төслийн саналыг хүргүүлээд байна.

### **Монгол туургатан театр:**

Аймаг орон нутгийн болон байгууллагуудын ойн арга хэмжээнд 11 удаа нийт 23 уран бүтээлч оролцож ажилласан.

### **Соёлын төвүүдийн үйл ажиллагааны хүрээнд:**



Албан байгууллагын дотоод ариутгал, халдваргүйтгэлийн ажлыг тогтмол хийлгэж, Нийтийн эзэмшлийн зам талбайн хог хаягдал, цас мөсийг цэвэрлэх ажлыг байгууллага, хамт олноороо зохион байгуулав. 2022 оны 01 дүгээр сард соён гэгээрүүлэх 8 арга хэмжээн зохион байгууллаа. Үүнд:

- МУСТА Гэрэлчулууны уран бүтээлийн тоглолт
- “Угийн бичгээ хөтөлж Удмийн сангаа цэвэр байлгая”
- “Аавуудын оролцоо”
- “Гэр бүл ба харилцаа”
- “Хүүхдийн хүмүүжилд аавуудын үүрэг” зэрэг сургалт, өдөрлөгийн арга хэмжээ
- Шинэ үндсэн хууль баталсаны 30 жилийн ойг угтсан Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөх ёслолын арга хэмжээ
- Гар бөмбөгийн тэмцээний шагнал гардуулах үйл ажиллагаа
- “Сээр” цохилтын тэмцээнүүдийг зохион байгууллаа.
- Нийтийн бүжиг зэрэг арга хэмжээнд нийт 620 иргэн хамрагдлаа.

### ***Зургаа. Санхүү, төрийн сангийн хэлтсийн хүрээнд:***

#### **Төсвийн орлогын талаар:**

Орлогын төлөвлөгөө эхний 12 дугаар сарын байдлаар орон нутаг 8243,1 сая төгрөг төвлөрүүлэхээс 12492,8 сая төгрөг төвлөрүүлж 151,6 хувьтай, 4249,7 сая төгрөгөөр орлогын төлөвлөгөө давж биелсэн байна. Аймгийн төвлөрсөн төсвийн орлого 18662,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 26227,9 сая төгрөг төвлөрүүлж 140,5 хувьтай, 7565,9 сая төгрөгөөр давж биелсэн. 3 шатны орлогын төлөвлөгөөний биелэлт нийт 11927,6 сая төгрөгөөр биелж, 135,9 %-тай байна. 3 шатны орлогын төлөвлөгөөгөө биелүүлсэн Алтанбулаг, Аргалант, Баяндэлгэр, Баянхангай, Баянцогт, Заамар, Лүн, Мөнгөнморьт, Өндөрширээт, Угтаал, Эрдэнэсант, Зуунмод зэрэг 12 сум, 2 шатны төлөвлөгөө биелүүлсэн Архуст, Баян, Баян-Өнжүүл, Баянцагаан, Баянчандмань, Дэлгэрхаан, Сэргэлэн, Цээл, Эрдэнэ зэрэг 9 сум, 1 шатны төлөвлөгөө биелүүлсэн Батсүмбэр, Баянжаргалан, Борнуур, Бүрэн, Жаргалант, Сүмбэр зэрэг нийт 6 сум байна.

#### **Төсвийн зарлага санхүүжилтийн талаар:**

Сумдад 2021 оны 12 дугаар сарын байдлаар нийт 97911,9 сая төгрөгийн зарлага санхүүжилтийг 27 сум, тэдгээрийн харьяа төсвийн байгууллагуудад олгосон.

#### **Салбараар авч үзвэл:**

Боловсрол шинжлэх ухааны сайдын багцаас 38366,0 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. Үүнд:

Ерөнхий боловсролын сургуулиудад 25830,3 сая төгрөг

- Хүүхдийн цэцэрлэгт 12535,7 сая төгрөг;
- Эрүүл мэндийн сайдын багцаас 10041,0 сая төгрөгийг олгосон.Үүнд:
- Сумдын эрүүл мэндийн төвд 9604,2 сая төгрөг
- Өрхийн эмнэлэгт 436,8 сая төгрөгийн санхүүжилтийг тус тус олгов.
- Газрын харилцаа,барилга хот байгуулалтын газарт 662,3 сая төгрөг,
- Гэр бүл, Хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт 514.0 сая төгрөгийн зарлага санхүүжилт тус тус олгоод байна.

Нийтийн ерөнхий үйлчилгээний салбарт 48328,6 сая төгрөгийн санхүүжилт олгосон.Үүнээс:

- Сумдын ИТХ,ЗДТГазар, Соёлын төвүүдийн санхүүжилтэд 16755,5 сая төгрөг
- Орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагуудад 31573,1 сая төгрөгийн санхүүжилт тус тус олгоод байна.

#### **Өр, авлагын талаар:**

2021 оны 12 дугаар сарын байдлаар сумд болон төсөвт байгууллагууд нийт 296,2 сая төгрөгийн авлага, 225,1 сая төгрөгийн өглөгтэй байна.

Нийт өглөгийн 95,5 сая төгрөг буюу 42.4 хувь нь түлш, халаалтын зардлын өглөг 7,9 сая төгрөг буюу 3.5 хувь нь цалингийн өглөг, 0.4 сая төгрөг буюу 0.1 хувь нь НДШимтгэлийн өр, 0,8 сая төгрөг буюу 0.4 хувь нь гэрэл цахилгааны зардлын өглөг, үлдсэн 120,5 сая төгрөг буюу 53.6 хувийг бусад өр эзэлж байна.

### Долоо. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн хүрээнд:

#### Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр:

“Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн 35 зорилтын 170 арга хэмжээний 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын Зөвлөлийн ээлжит бус II хуралдаанаар хэлэлцүүлж 90.33 хувьтайгаар Засгийн газарт тайлагналаа.

Төв аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн зорилт тус бүрийн дундаж үнэлгээгээр:

- Үндэсний нэгдмэл үнэт зүйл 100 хувь
- Хүний хөгжил 90.22 хувь
- Амьдралын чанар ба дундаж давхрага 89.35 хувь
- Эдийн засаг 89.41 хувь
- Засаглал 91.49 хувь
- Ногоон хөгжил 91.82 хувь
- Амар тайван, аюулгүй байдал 90.03
- Бүс орон нутгийн хөгжил 88.48 хувьтай дүгнэгдсэн байна.




Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 4 бодлогын 20 арга

хэмжээний 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцын тайланг аймгийн Засаг даргын Зөвлөлийн ээлжит бус II хуралдаанаар хэлэлцүүлж 95 хувьтай байгаа нь өмнөх оны жилийн эцсийн байдлаас 6.5 пунктээр өссөн байна. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан 4 бодлогын 20 арга хэмжээний 2021 оны жилийн эцсийн хэрэгжилтийн явцын тайланг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний цахим сан ([www.new.unelgee.gov.mn](http://www.new.unelgee.gov.mn))-д хугацаа хоцроолгүй тайлагналаа.

Хүснэгт – I Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн товчоо.

Бүлэг	Арга хэмжээ	Үр дүнтэй	Тодорхой үр дүнд хүрсэн	Эрчимжүүлж шаардлагатай	Үр дүнгүй	Дундаж үнэлгээ
		100%	70-99%	31-69%	0-30%	
Эдийн засгийн бодлого	7	5	-	2	-	85.71%
Засаглалын бодлого	4	4	-	-	-	100%
Ногоон хөгжлийн бодлого	3	3	-	-	-	100%
Нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлого	6	6	-	-	-	100%
<b>Нийт</b>	<b>20</b>	<b>17</b>	<b>1</b>	<b>2</b>	<b>-</b>	<b>95%</b>

График – I 2020, 2021 оны жилийн эцсийн дүнгийн харьцуулалт



#### Санхүүгийн хяналт, аудитын чиглэлээр:

2022 оны 01 дүгээр сарын байдлаар Санхүүгийн хяналт, аудитын албаны 2021 оны төлөвлөгөөний дагуу Төсвийн тухай хуулийн хэрэгжилт, төсвийн хөрөнгийн зарцуулалтад аймгийн

- Засаг даргын Тамгын газар,
- Санхүү төрийн сангийн хэлтэс,
- Засаг даргын тусгай сан,
- ОНХС,
- Төв Чандмань ДЭХГ-ын 2019-2020 оны санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж 3,365,222.2 төгрөгийн зөрчил илрүүлж 43,854.6 төгрөгийн зөрчилд улсын ахлах байцаагчийн акт, 135,593.8 мянган төгрөгийн зөрчилд улсын байцаагчийн албан шаардлага, 3,185,773.8 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгч ажиллалаа.

***Найм. Цэргийн штабын хүрээнд:***

2022 оны цэргийн бүртгэл 01 дүгээр сарын 03-наас 01 дүгээр сарын 28-ны өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байна. Төв аймгийн 27 сумын хэмжээнд Цэргийн бүртгэл 01 дүгээр сарын 25-ны өдрийн байдлаар 84.7 хувьтай байна. Энэ жилийн хувьд Төрийн цахим систем "E-mongolia"-д Монгол Улсын Батлан хамгаалах яам нэгдсэнтэй холбогдуулж 2022 оны цэргийн бүртгэлийг цахимаар зохион байгуулж байгаа бөгөөд аймгийн хэмжээнд 1938 иргэн аппликейшн ашиглан цэргийн бүртгэлд хамрагдсан байна.

Төв аймгийн Засаг даргын Тамгын газар